2019
№ 03 (30)



ШҮҮХИЙН ШИЙДВЭР
ГҮЙЦЭТГЭЛ СУДЛАЛ

Онол-арга зүйн улирал тутмын сэтгүүл

Улаанбаатар

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬД ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН АЖИЛТНЫГ СУРГАН БЭЛТГЭЖ БУЙ БАЙДАЛ



Ш.ЛХАЧИНЖАВ
Дотоод хэргийн их сургуулийн захирал
доктор (Ph.D), профессор, хошууч генерал

Ази, Номхон далайн орнуудын хорих байгууллагуудын удирдах ажилтнуудын 39 дэх бага хуралд оролцогч эрхэмсэг хатагтай, ноёд та бүхний амрыг эрэн мэндчилье. Энэхүү бага хурлыг манай улсад анх удаа зохион байгуулж буйд бид талархаж байгаа бөгөөд бага хурал Монгол Улсын хорих байгууллагын алба хаагчдыг бэлтгэдэг үндсэн сургууль болох Дотоод хэргийн их сургуулийн түүхт 85 жилийн ойтой давхцаж байгаагаараа онцлог байна.

Дотоод хэргийн их сургууль нь Монгол Улсын хууль зүй, дотоод хэргийн салбарын мэргэшсэн албан хаагчдыг 1934 оноос хойш өнөөдрийг хүртэл бэлтгэж ирсэн, Монгол Улсын дээд боловсролын тогтолцоонд баттай байр суурийг эзэлсэн Монголын үндэсний ууган сургуулиудын нэг юм.

Хөгжлийнхөө түүхэн хугацаанд нийгмийг аюулаас хамгаалах, үндэсний аюулгүй байдлыг хангах, хууль зүй, дотоод хэргийн салбарын дээд боловсролтой эрх зүйч, команд-улс төрийн ажилтан мэргэжлүүдээр нийт 20 мянга гаруй, мөн 40 мянга орчим мэргэжлийн албан хаагчдыг бэлтгэж, эдгээр мянга мянган төгсөгчид маань эх орныхоо өнцөг булан бүрт тушаал өвөртлөн ажиллаж, нэр хүндтэй, хариуцлагатай үйлс болох гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам хамгаалах, олон нийтийн аюулгүй байдлыг хангах, улсын хил хамгаалах, хорих байгууллагын аюулгүй байдал, шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх, шинжлэн магадлах, гамшгаас урьдчилан сэргийлэх, авран хамгаалах ажиллагааг нэр төртэй гардан хэрэгжүүлэн ажиллаж байна.

Дотоод хэргийн их сургууль нь өнөөдөр эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн шинж бүхий дээд боловсролын төрийн өмчит, нэгдмэл

төвлөрсөн удирдлагатай, төрийн чиг үүргийн бие даасан байгууллага бөгөөд Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэн, Хилийн албаны сургууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль, Цагдаагийн сургууль, Онцгой байдлын сургууль, Эрх зүй, нийгмийн ухааны сургууль, Ахлагчийн сургууль, Ахисан шатны боловсролын сургууль, Удирдлагын академи, Шинжлэн магадлахуйн институт, Ерөнхий боловсролын ахлах сургууль гэсэн бүрэлдэхүүн болон харьяа 10 сургууль, тусгай факультет, штаб, газар, хэлтэс, алба, багшийн хөгжлийн төв, эрүүл мэндийн төв болон бусад нэгжийн дэмжлэгтэйгээр мэргэжлийн боловсрол, бүрэн дунд, бакалавр, магистр, докторын шаталсан сургалтын хэлбэрээр 50 гаруй хөтөлбөрийг хэрэгжүүлж, судалгааны тэргүүлэх 30 орчим чиглэлээр эрдэм шинжилгээний үйл ажиллагаа явуулж байна.

Манай сургууль хууль зүй, дотоод хэргийн салбарын шинжлэх ухаан, боловсролын хөгжилд тэргүүлэх байр суурьтай, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн, үндэсний болон бүс нутгийн аюулгүй байдлыг хангах үйл хэрэгт хувь нэмэр оруулагч, мэдлэг оюуны төв байхаар алсын хараагаа тодорхойлж, хууль зүй, дотоод хэргийн салбарын сургалт, эрдэм шинжилгээ, судалгаа, инновацийн хөгжлийн гол түшиц байгууллага болохоор зорин ажиллаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийг бэлтгэж буй байдал

Анх 1974 онд Нийгмийг аюулаас хамгаалах яамны Цэргийн тусгай дунд сургууль, 1982 онд Цэргийн дээд сургууль, 1990 оноос Цагдаагийн дээд сургууль, 2000 оноос Цагдаагийн академи, 2011 онд Дотоод хэргийн их сургууль байгуулагдан ажилласан бүхий л хугацаанд хуучнаар Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн байгууллага, Хорих байгууллагуудын удирдах газар өнөөгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хүний нөөцийг бэлтгэж ирсэн.

Тус Их сургуулийн харьяанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдыг бэлтгэх нэгжийг "Засан хүмүүжүүлэх хөдөлмөрийн эрх зүй ба салбар эрх зүйн тэнхим (1986-1996)", "Эрүүгийн ял эдлүүлэх эрх зүйн тэнхим (1996-2000)", "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын ажилтныг бэлтгэх факультет (2000-2007)", "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх эрх зүйн тэнхим (2007-2011 он)" нэртэйгээр үйл ажиллагаагаа явуулж ирсэн ба Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 229-р тогтоолоор байгуулагдсан Дотоод хэргийн их сургуулийн бүтцэд

"Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль" нэрээр их сургуулийн бүтцийн үндсэн нэгж буюу бүрэлдэхүүн сургуулийн статустай болж өргөжсөн.

Судалгаанаас үзэхэд 1974-2014 оныг хүртэл хугацаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 1000 гаруй мэргэжилтэн төгссөн[1] ба сүүлийн 15 жилийн хугацаанд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын чиглэлээр бакалаврын сургалтын хөтөлбөрийг 521 мэргэжилтэн төгсжээ[2].

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага нь эрүү, иргэн, захиргаа, зөрчлийн хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэрийг гүйцэтгэх чиг үүрэг бүхий төрийн тусгай байгууллага бөгөөд энэхүү хуулиар хүлээсэн чиг үүргээ гүйцэтгэхэд мэргэшсэн төрийн албан хаагч чухал шаардлагатай. Дотоод хэргийн их сургуулиас дээрх шаардлагыг хангах өндөр "МЭДЛЭГ-УР ЧАДВАР-ХАНДЛАГА" бүхий мэргэжилтэн бэлтгэх зорилгоор сургалтын хөтөлбөрийн шинэчлэлтийг олон улсын болон нийгмийн хөгжлийн чиг хандлагад нийцүүлэн хэрэгжүүлж байна.

Тус Их сургуульд өнөөдрийн байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын албан хаагчдыг дараахь шаталсан сургалтын тогтолцоогоор бэлтгэж сургаж байна.Үүнд:

1.Харуул хамгаалалтын ажилтныг бэлтгэх сургалт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газарт зохион байгуулагдаж байсан 14 хоногийн томилогчдохын өмнөх сургалтыг 2013 оноос хойш тус Их сургуулийн харьяа Ахлагчийн сургуульд явуулдаг болсноор "Харуул хамгаалалтын албаны ажилтан" мэргэжлийн сургалтын хугацааг сунгах, сургалтын хөтөлбөрийг шинээр боловсруулахад анхааран ажиллаж сургалтыг 3 сар, үйлдвэрлэлийн дадлагыг 21 хоног болгон сургалтын хөтөлбөр, агуулгад өөрчлөлт оруулсны дүнд богино хугацааны сургалт буюу 2-3 сарын сургалтаар нийт 1402 суралцагчийг "Харуул хамгаалалтын албаны ажилтан" мэргэжлээр амжилттай сурган төгсгөжээ.

2.Бакалаврын сургалт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургууль нь 2017-2018 оны хичээлийн жилд "Аюулгүй байдал-хууль сахиулах ажил", "Нийгмийн ажил", "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх-хууль сахиулах ажил" хөтөлбөрийг хэрэгжүүлэн ажиллаж байсан бөгөөд 2019-2020 оны хичээлийн жилээс захиалагч байгууллагын алба хаагчид тавигдах шаардлагыг үндэслэн

[1] А.Лхагва.Тэнхимээс сургууль болж өргөжсөн түүхэн замнал.УБ.,2014 он. 7 дах тал

[2] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хүний нөөцийн хэлтсийн тоон судалгаа 2019 он.

"Шүүхийн шийдвэр гүйцэтгэл-эрх зүй", "Нийгмийн ажил" зэрэг хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

2019 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар "Шүүхийн шийдвэр гүйцэтгэл-эрх зүй" хөтөлбөрөөр өдрийн ангид 260, эчнээ 3 жилийн ангид 69, 5 жилийн эчнээ ангид 56 суралцагч, "Нийгмийн ажил" хөтөлбөрөөр 20 сонсогч суралцаж байна.

Бакалаврын сургалтын хувьд суралцагчид 120 кредит цагийн хичээлийг судлан, тэнхимийн сургалтаас гадна захиалагч байгууллагын харьяа хорих ангиудад харуул хамгаалалт, нийгмийн ажил мэргэжлийн дадлагын ажлыг хийдэг.

Сонсогч, суралцагчидад сургалтын үйл ажиллагаанаас гадна бие даан болон багаар ажиллах ур чадварыг эзэмшүүлэх хүрээнд чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх зорилгоор илтгэх, мэтгэлцэх урлагийн чадвар олгох "Бүргэдүүд", албаны бэлэн байдал, бие бялдрын бэлтгэлжилт, бялдаржуулах урлагийн "Хар ирвэс" клубт суралцаж байна.

2019-2020 оны хичээлийн жилээс бакалаврын сургалтын суралцагчидыг 1-2 дугаар дамжаанд нь их сургуулийн дотуур байранд байрлуулан бие даан суралцахад дэмжлэг үзүүлэн, өнгөрсөн хичээлийн жилээс "MIU" олон улсын сургуулийн англи хэлний сургалтад хамруулж эхэлсэн нь гадаад хэлний өндөр мэдлэгтэй алба хаагчдыг бэлтгэхэд урагш алхсан алхам болсон.

2019 оны 04 дүгээр сарын 24-ний өдөр Дотоод хэргийн их сургууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар "Хамтран ажиллах санамж бичиг"-ийг шинэчлэн батлаж хүний нөөцийг бэлтгэх ажлын хүрээнд хэд хэдэн ажлыг хамтран зохион байгуулахаар тохиролцсон. Тухайлбал, ШШГЕГ-т ашигладаг програм хангамжийг сургалтын зорилгоор ашиглах, ШШГЕГ-ын харьяа 421 дүгээр нээлттэй, 409 дүгээр хаалттай, Цагдан хорих 461 дүгээр хаалттай хорих анги, Нийслэлийн шийдвэр гүйцэтгэх газар, Банк, хадгаламж зээлийн хоршоодоос төлбөр барагдуулах ажлын албыг сургалтын түшиц газар болгох, судалгааны ажлыг бодлогын түвшинд дэмжиж, практик алба хаагчдын оролцоог нэмэгдүүлэх, Дотоод хэргийн их сургуулийн шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн чиглэлээрх профессор, багш, алба хаагчдыг мэргэжлийн мэдлэг, ур чадвар, туршлага харгалзан томилон ажиллуулах хүрээнд олон асуудлыг хамтран шийдвэрлэсэн юм.

3.Магистрын сургалт

Дотоод хэргийн их сургуульд 2000-2018 оны хооронд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 125 алба хаагч магистрын зэрэг хамгаалсан ба 2000-2005 онд жилд дунджаар 2 алба хаагч Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын чиглэлээр магистрын зэрэг хамгаалж байсан бол 2006-2012 онд 11, 2013 оноос тоон үзүүлэлт өсч жилд дунджаар 20–аас доошгүй алба хаагч магистрын зэрэг хамгаалах болжээ.

2019-2020 оны хичээлийн жилд тус их сургуульд Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 33 алба хаагч магистрын сургалтад хамрагдаж байна.

4.Докторын сургалт

Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдын 2014 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн а/168 дугаар тушаалаар тус Их сургуулийн дэргэд "Докторын ажил хамгаалуулах зөвлөл" байгуулагдсан ба Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын салбарын эрдэмтэд 2015 оноос хойш жил бүр 1 алба хаагч хорих ял эдлүүлэх ажиллагаанд хамаарах сэдвээр эрдмийн зэрэг хамгаалж байгаа нь тус салбарын судалгаа, шинжилгээний ажил ихээхэн эрчимтэй хөгжиж буйг харуулж байна. Тус их сургуульд өнөөдрийн байдлаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын 19 алба хаагч докторантурын сургалтад хамрагдаж байна.

5.Удирдах ажилтан бэлтгэх сургалт (шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн стратеги, тактик, удирдлагын өдөр, эчнээ 2 жилийн сургалт)

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын захиалгаар "Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн стратеги-тактик, удирдлага" мэргэжлийн сургалтын хөтөлбөрийн дагуу удирдахуйн ухааны албан тушаалын, стратегийн дамжаанд суралцагчдад тусгайлсан хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу богино хугацааны сургалтыг явуулж байна. "Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн стратеги-тактик, удирдлага" сургалтын хөтөлбөрөөр 2014-2018 оны хугацаанд нийт 13 албан хаагч төгссөн байх бөгөөд өнөөдрийн байдлаар ШШГЕГ-ын харьяа анги, нэгжид дарга, дэд дарга, ахлах мэргэжилтний түвшинд ажиллаж байна.

"Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн стратеги-тактик, удирдлага" мэргэжлийн сургалтын хөтөлбөрийн хүрээнд суралцагчдад өнөөгийн хүчин төгөлдөр хууль тогтоомжид нийцүүлэн эрүү, иргэн, захиргааны хэргийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын талаарх мэдлэг олгох сургалтыг зохион байгуулахаас гадна практик

байгууллагатай хамтран клиник сургалт, дадлага, "Команд-штабын сургалт"-ыг хорих анги, шийдвэр гүйцэтгэх албаны бодит орчинд, тусгайлсан төлөвлөгөөний дагуу өгөгдөл өгч, болзошгүй бүхий л нөхцөлд ажиллах дадлага, чадвар эзэмшүүлэх зорилгоор зохион байгуулж байна.

Энэ хичээлийн жил Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын захиалгаар нийт 18 албан хаагч суралцаж байна.

Их сургуулийг хотхон хэлбэрээр хөгжүүлэх хүрээнд хичээлийн төв байрыг ашиглалтад оруулснаас гадна төв номын сан, биеийн тамирын цогцолборын шинэ байрыг 2020 онд ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна.

Дотоод хэргийн их сургуулиас сургалтын үйл ажиллагаанд чанарыг эрхэмлэх, их сургуулийн үнэт зүйл болох профессор, багш нарын эрдэм шинжилгээ, судалгааны идэвхи, чадавхийг нэмэгдүүлэх, сургалтын хөтөлбөрийг боловсролын шинэ эрэлт хэрэгцээнд нийцүүлэх, сургалтын технологи, арга зүйг сайжруулах, онол практикийн хичээлийн зохистой харьцааг бий болгох, суралцагчийн хөгжлийг хангасан орчин нөхцөлийг бүрдүүлэх, үр дүнг бодитой үнэлэхийн тулд дотоод хяналт, чанарын баталгаажуулалтыг хөгжүүлэх, олон улсын болон дотоодын магадлан итгэмжлэл хийлгэх, чанарын хяналтыг системтэйгээр хэрэгжүүлэх асуудалд анхаарлаа хандуулан ажиллаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын хөгжил

Эрүү, иргэн, захиргааны хэргийн талаар гарсан шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны чиглэлээр эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг гүйцэтгэх үндсэн чиг үүрэг бүхий Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын профессорын судалгааны баг нь Их сургуулийн эрдмийн зөвлөлийн 2013 оны 12 дугаар сарын 06-ны өдрийн "Профессорын баг байгуулах тухай" 6 дугаар тогтоолоор байгуулагдан үйл ажиллагаагаа явуулж байна.

Профессорын судалгааны багийн бүрэлдэхүүнд Дотоод хэргийн их сургуулийн шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын салбарын эрдэмтэн, судлаачид болон Монгол Улсын их сургууль, Шинжлэх ухаан технологийн их сургуулийн эрдэмтэн судлаачид багтаж байгаа бөгөөд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдах алба хаагчид клиникийн профессор, зөвлөх профессороор ажиллаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын профессорын судалгааны баг нь салбарын хэмжээний эрдэм шинжилгээний ажлын гүйцэтгэл, үр дүнг

хариуцан, магистр, докторын сургалтын суралцагчдыг судалгааны ажлыг удирдан чиглүүлж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын профессорын судалгааны баг нь ШШГЕГ-тай хамтран Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн салбарын тулгамдсан асуудлыг нээн илрүүлэх, шийдвэрлэх арга замын талаарх эрдэмтэн, судлаач, практик алба хаагчдын санал, зөвлөмжийг судалгааны эргэлтэд оруулах зорилго бүхий эрдэм шинжилгээний хурлыг 2012 оноос 2019 оныг хүртэл 10 удаа зохион байгуулснаас албан хаагчдын сургалт-3, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны эрх зүйн орчин-4, хорих байгууллагад явуулах нийгэмшүүлэх ажил-2, хоригдлын үйлдэх гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр-1 гэсэн сэдвийн хүрээнд явуулж иржээ.

Түүнчлэн суралцагчдыг салбарын хэмжээний эрдэм шинжилгээний ажилд татан оролцуулах зорилго бүхий "Шилдэг илтгэл, уран илтгэгч", "Парлиаментын мэтгэлцээн", "Оюуны индэр" тэмцээн, уралдааныг жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг.

2016-2019 оны хооронд Шинжлэх ухаан, технологийн сан, олон улсын байгууллагын санхүүжилтээр 320 гаруй сая төгрөгийн төсөл, хөтөлбөр /Хорих ял эдлүүлэх чиглэлээрх мэргэжлийн судлаачдыг чадавхжуулах нь, Дэлхийн зарим улс орнуудын хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагааны харьцуулсан судалгаа/-ийг хэрэгжүүлсэн нь тус салбарын судалгааны ажлын чанар, үр дүнг нэмэгдүүлэх, шинэ инновацийг бий болгоход чиглэсэн чухал ач холбогдолтой ажил болсон.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын захиалгаар болон практик алба хаагчдын хамтын ажиллагааны хүрээнд хамтарсан судалгаа-боловсруулалтын ажлыг хийн, үр дүнг практикт нэвтрүүлэх ажил улам эрчимжиж байна.

Монгол Улсын Дотоод хэргийн их сургууль нь Ази-Номхон далайн орнуудын хорих байгууллагуудтай хамтарсан судалгаа-шинжилгээний ажил гүйцэтгэх, харилцан туршлага судлах, тухайн орны хорих байгууллагын ажилтныг бэлтгэдэг сургуулиудтай "судлаач, багш, оюутан" солилцох зэргээр сургалт, судалгааны чиглэлээр бүх талын хамтын ажиллагааг өргөжүүлэх сонирхолтой байгааг энэ дашрамд илэрхийлэхийн зэрэгцээ хурлын үйл ажиллагаанд амжилт хүсье.

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН ЭРХ ЗҮЙН ОРЧИН ТҮҮНИЙГ БОЛОВСРОНГУЙ БОЛГОХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА



Б.БАТБОЛД
Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн захрирал, хурандаа

Хураангуй: Дэлхийн дийлэнх орнууд ард иргэдийнхээ боловсролын түвшинд ихээр анхаарч байна. Үүнийг даган тус чиг үүргийг хэрэгжүүлдэг боловсролын байгууллагын бие даасан байдлыг бэхжүүлэх, эрх зүйн орчинг бий болгох шаардлага бий болсон гэж үзэж байна. Илтгэлд Дотоод хэргийн их сургуулийн эрх зүйн орчны асуудлуудыг судлан авч үзсэн.

Abstract: The vast majority of countries around the world are paying close attention to their educational level. It is imperative to strengthen the independence of educational institutions that implement these functions and create a legal environment. The article is devoted to the analysis of issues legal sphere of University of internal affairs of Mongolia.

Түлхүүр үг: Дотоод хэргийн их сургууль, эрх зүйн байдал, хөтөлбөр, сургалтын байгууллага.

Keywords: University of internal affairs of Mongolia, legal status, training programs, educational institution.

Өнөө үед дэлхийн улс орнууд ард иргэдийнхээ боловсролд гол анхаарлаа хандуулж, боловсролын салбарт оруулсан хөрөнгө оруулалтаар тухайн улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдал, хөгжил, оршин тогтнох байдал хэмжигдэж улс орныхоо хөгжлийн чиг хандлагыг тодорхойлж иржээ. Тусгаар улсуудын ард иргэд хэдий чинээ боловсрол, мэдлэгтээ анхаарснаар тухайн улс орны оршин тогтнох үндэс баталгаатай байхыг хүлээн зөвшөөрсөн байдаг.

Хүнийг сургах гэдэг нь эртний Педагогик (pedagogy) буюу сургалт гэдэг нь грек гаралтай үг бөгөөд "пайдос" – хүүхэд, "аго" – дагуулж явах,

шууд утгаараа хүүхдийг дагуулж явах гэсэн утгатай[1]. Эртний Грекд эзнийхээ хүүхдийг сургууль руу дагуулж явж байгаа боолыг ийнхүү нэрлэдэг байсан бөгөөд, сургуульд нь өөр нэг боол-эрдэмтэн хичээл заадаг байсан байна. Цаг хугацаа өнгөрсөөр энэхүү ойлголт нь *"хүүхдийг амьдралд хөтлөх"* болж хувьсан өөрчлөгджээ. Харин XIX зууны сүүл үе XX зууны эхэн үеэс сургалт нь зөвхөн хүүхдэд гэлтгүй насанд хүрсэн хүнд ч хэрэгтэйг тодорхойлсон олон онол урсгалүүсэн хөгжиж ирсэн.

Сургалтын үйл ажиллагааны түүхэн хөгжлийг авч үзвэл анхны сургуулиуд Эртний Египет, Грек, Ромд байгуулагдаж, Александрийскийн их сургууль нэртэйгээр манай эрний V зуунд хамгийн анхны их сургууль байгуулж, тухайн сургууль нь 13 лекцийн танхимтай, 5000 гаруй суралцагчдыг багтаах боломжтой байсныг гэрчилсэн олдворыг археологчид илрүүлжээ[2]. Өнөөдрийг хүртэл үйл ажиллагаагаа явуулж байгаа эртний их сургуулийн талаар эрдэмтэд тодорхойлохдоо 859 онд Мароккод байгуулагдсан Каруаны их сургууль буюу зарим эх сурвалжаас энэ нь их сургууль бус исламын шашины төв байсан гэж ойлгож болохоор байдаг нь их сургуулийн үүсэл хөгжлийн түүх өнөөг хүртэл маргаантай хэвээр байгааг харуулж байна. Европ тивд анхны их сургуулиуд Италийн Болони хотод, 1200 онд Парисийн их сургууль, 1209 онд алдарт Кембрижийн их сургууль, 1348 онд Прагийн их сургууль, 1365 онд Чехийн их сургууль байгуулагдсан нь их сургууль улс орны хөгжлийн хандлагыг чиглүүлдэг онолын үүднээс авч үзвэл Европ тивийн хөгжилд ихээхэн хувь нэмэр оруулсан байдаг.

Монгол Улсад улс орны аюулгүй байдлыг хангах чиг үүрэг бүхий хүний нөөцийг бэлтгэх гол түшиц бааз болсон манай Их сургуулийн түүхэн 85 жилийн ойэнэ жил тохиож байна. Дотоод хэргийн их сургуулийн түүхэн хөгжил дэлхийн бусад орны их сургуулиудтай харьцуулбал ихээхэн залуу хэдий ч Монгол Улсад байгуулагдсан 2 дахь их сургууль гэдгээр нь нийт ажиллаж байгаа эрдэмтэн, багш, судлаач, сурч байгаа сонсогч суралцагчид, үе үеийн төгсөгчид маань төрөлх сургуулиараа бахархах нь зүйтэй юм.

Дотоод хэргийн их сургууль нь Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяанд үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд төрийн тусгай

[1] https://dic.academic.ru/dic.nsf/ruwiki/19903
[2] http://vladhistory.com/istoriya-poyavleniya-pervyx-shkol/
http://www.para.by/articles/text/samyi-pervyi-universitet

чиг үүрэг бүхий мэргэшсэн алба хаагчдыг бэлтгэдэг боловсролын дээд байгууллага билээ.

Дотоод хэргийн их сургууль нь Монгол Улсын Засгийн газрын агентлагууд болох цагдаагийн байгууллага, хил хамгаалах, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын болон шүүхийн шинжилгээний байгууллагуудын мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх зорилгоор Дээд боловсролын тухай хууль тогтоомжийн хүрээнд бакалавр, магистр, докторын зэрэг олгох сургалт эрхлэхээс гадна судалгааны ажил зонхилсон лаборатори бүхий эрдэм шинжилгээ-сургалт-үйлдвэрлэлийн нэгдэл хэлбэртэй дээд боловсролын байгууллага бөгөөд шүүх эрх мэдлийн байгууллага, Прокурор, Архив, Улсын бүртгэл, Гадаадын иргэн, харьяат, Хууль зүйн үндэсний хүрээлэн, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг, Гааль, Татвар, Нийгмийн даатгалын болон бусад төрийн байгууллага болон их дээд сургуулийн багш, судлаач, алба хаагчдыг магистр, докторын зэргийн сургалтад хамруулж, удирдах ажилтан болон судлаач мэргэжилтэн бэлтгэдгээрээ онцлогтой.

Сүүлийн жилүүдэд судлаачид их сургуулийн бие даасан байдлыг хангах зайлшгүй шаардлагатайг онцолж ирсэн бөгөөд тусгай хууль тогтоомжоор төрийн өмчийн их сургуулиудад нийтийн статус олгох, эрх тэгш хөгжих боломжоор хангах асуудлыг хөндсөөр байна.

Их сургуулийн эрх зүйн байдлыг тусгайлсан хуулиар зохицуулах боломж, жишиг байгаа эсэхийг судлан ОХУ-ын нийслэл Москва хот, Санкт-Петербург хотод байрлах нэр бүхий сургуулиуд болох М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн их сургууль, Санкт-Петербургийн их сургуулийн эрх зүйн байдал нь "М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн их сургууль болон Санкт-Петербургийн их сургуулийн" тухай Холбооны хуулиар зохицуулагддаг[3]. Тухайн хуулийн 1 дүгээр зүйлд энэхүү хуулиар Оросын Холбооны Улсын тэргүүлэх, сонгодог сургуулиуд болох М.В. Ломоносовын нэрэмжит Москвагийн их сургууль, Санкт-Петербургийн их сургуулийн эрх зүйн байдлыг тодорхойлно гэж заасан байдаг.

Гэхдээ эдгээр их сургуулиуд нь 200-290 жилийн өмнө үүсгэн байгуулагдсан арвин туршлагатай өөрийн гэсэн судалгааны чиглэл тогтсон сургуулиуд болохыг онцлох нь зүйтэй.

Орчин үеийн сургуулиуд дунд ч мөн өөрийн гэсэн салбар хуультай сургуулиуд ч байдаг байна. Үүний тод жишээ нь Бүгд Найрамдах Казахстан

[3] https://rg.ru/2009/11/13/universitety-dok.html

улс юм. Эрх зүйн тогтолцооны хувьд хурдацтай хөгжиж байгаа Бүгд Найрамдах Казахстан Улсын хувьд ч их сургуулийн эрх зүйн статусыг тодорхойлсон хуультай болох асуудалд анхаар "Назарбаевын их сургууль"-ийн эрх зүйн байдыг тодорхойлсон Бүгд Найрамдах Казахстан Улсын "Назарбаев их сургууль, Назарбаев сэтгэн бодох сургууль, Назарбаев сан"-гийн тухай хуулийг 2010 онд баталсан байдаг[4].

Үүнээс гадна эдийн засгийн хувьд хөгжингүй улсууд ч их сургуульд зориулсан тусгайлсан хуулиудтай байдаг жишиг байна. Жишээлбэл, Өмнөд Солонгос Улсад "Сөүлийн үндэсний их сургуулийн тухай" хууль (2014), "Улсаны шинжлэх ухаан, технологийн үндэсний институтын тухай" хууль (2013), Холбооны Бүгд Найрамдах Герман Улсад "Шпэерийн захиргааны шинжлэх ухааны их сургуулийн тухай" Райланд-Пфальц мужийн хууль (2010) юм.

Доктор, профессор Б.Бат-Эрдэнэ, Ж.Эрдэнэбулган нар дээрх орнууд их сургуульдаа тусгайлсан хуулийг баталсан гол үндэслэл нь тус орны сургуулиудын өвөрмөц байдал мөн бөгөөд их сургуулийн бие даасан байдлыг хангах, түүний өвөрмөц тогтолцоо нь, уламжлал, үнэт зүйл, профессор багш, тэргүүлэх эрдэмтдийн үйл ажиллагааг улс төр, нийгэм, эдийн засгийн сөрөг хүчин зүйлээс хамгаалах гол дархлаа болж байгаагаараа онцлог байна гэж тэмдэглэсэн байдаг[5].

Монгол Улсад Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа 10 агентлаг, байгууллагууд үйл ажиллагаагаа явуулж байна. Дотоод хэргийн их сургуулийн хувьд байгууллагын статустай хэдий ч Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагуудын алба хаагчдыг бэлтгэж байгаа бөгөөд Дээд боловсролын тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль гэх мэт салбар хууль тогтоомжуудыг удирдлага болгон ажиллаж байгаа юм. Харин хүний нөөцийн захиалагч байгууллагуудын үйл ажиллагаа Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, салбарын эрх зүйн баримт бичгээр зохицуулагдаж байна.

Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа агентлагуудын удирдлагыг Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 18[3] дугаар зүйлд заасны дагуу Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газар 6 жилийн

[4] https://online.zakon.kz/Document/?doc_id=30914968#pos=1;-65

[5] Б.Бат-Эрдэнэ, Ж.Эрдэнэбулган. Дээд боловсролын засаглал эрх зүйн асуудал, шийдэл.

хугацаагаар томилж, чөлөөлдөг бөгөөд Дотоод хэргийн их сургуулийн хувьд статусаас хамааран нарийвчилсан зохицуулалт одоогоор байхгүй байна. Дотоод хэргийн их сургуулийн хувьд батлагдсан бүтэц, орон тооны дээд хязгаарыг бусад төрийн зарим чиг үүрэг бүхий байгууллагатай харьцуулбал хамрах хүрээ их, алба хаагчийн орон тооны дээд хязгаараас илүү байгаагаас үзвэл төрийн тусгай чиг үүрэг бүхий алба хаагч, хүний нөөцийг бэлтгэн гаргадаг онцлогыг харгалзан үзэж цаашид тус их сургууль нь бие даасан эрх зүйн зохицуулалттай байж болох зайлшгүй хэрэгцээ, шаардлага үүссэн байж болох талтай.

Өөрөөр хэлбэл Дотоод хэргийн их сургуулийг Монгол Улсын Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болгох хэрэгцээ, шаардлага бий болсон гэж үзэж байна.

Хэрэв Дотоод хэргийн их сургууль нь бие даасан эрх зүйн зохицуулалттай болвол Монгол Улсын Засгийн газар өөрчлөгдөх, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн өөрчлөгдсөн ч Их сургуулийн алба хаагчид нь Төрийн албаны тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх зүйн баталгаагаар хангагдана. Түүнчлэн Төрийн албаны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.5 дахь хэсэгт заасан *"Тухайн байгууллагын чиг үүрэгт хууль тогтоомжоор өөрчлөлт орсноос бусад тохиолдолд энэ хуулийн 23.3-т заасан тусгай шаардлага болон албан тушаалын тодорхойлолтод өөрчлөлт оруулахыг хориглоно"* гэсэн хууль зохицуулалт үйлчлэх юм.

Дотоод хэргийн их сургуулийн түүхэн замналын хувьд БНМАУ-ын Ардын сайд нарын зөвлөлийн (хуучин нэрээр) 1933 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 8 дугаар тогтоолоор Дотоодыг хамгаалах газрын дунд сургууль байгуулж байжээ. 1934 оны 09 дүгээр сарын 19-ний өдөр Дотоодыг хамгаалах газрын даргын 687 дугаар тушаалаар сургуулийн захирлыг томилон орон тоог баталсанаар "Төв сургууль" байгуулагдсан түүхтэй бөгөөд өнөөдрийг хүртлэх хугацаанд нийт 12 удаа өөрчлөн зохион байгуулагдсан[6].

Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 229 дүгээр тогтоолоор Хууль зүй, дотоод хэрэг, тагнуулын салбарын боловсон хүчин бэлтгэх, давтан сургах тогтолцоог боловсронгуй болгох, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын уялдааг сайжруулах зорилгоор Цагдаагийн академи, Үндэсний

[6] Дотоод хэргийн их сургуулийн вэб сайтаас http://www.leu.gov.mn/page/853.shtml?sel=1584&subsel=1606

тагнуулын академи, Хилийн цэргийн дээд сургуулийг нэгтгэн Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяанд Дотоод хэргийн их сургуулийг байгуулж байсан[7].

2012 оноос хууль зүйн салбарын шинэчлэлийн хүрээнд Монгол Улсын Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 13-ны өдрийн 87 дугаар тогтоолоор Дотоод хэргийн их сургуулийг Хууль сахиулахын их сургууль болгон өөрчлөн зохион байгуулсан[8].

Гэтэл Монгол Улсын Их Хурлын 2016 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн 26 дугаар тогтоолоор Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 53 дугаар зүйлд заасан журмын дагуу Улсын Их Хурлын эцсийн найруулгатай танилцах, ёсчлох, Монгол Улсын Ерөнхийлөгчид илгээх, "Төрийн мэдээлэл" эмхэтгэлд хэвлэн нийтлэх ажиллагаанууд хийгдээгүй үндэслэлээр Хууль сахиулах ажиллагааны тухай хууль болон бусад хуулиудыг хууль санаачлагчид нь буцаасан байдаг[9].

Дээрх хууль нь батлагдаагүй гэх үндэслэлээр Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 152 дугаар тогтоолоор Хууль сахиулахын их сургуулийг Дотоод хэргийн их сургууль болгон өөрчлөн зохион байгуулсан бөгөөд тус Их сургуулийн дүрэм, бүтэц, орон тооны хязгаарыг баталж мөрдүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн Сайдад даалгасан[10].

Дээр дурдсан Монгол Улсын Засгийн газраас гаргасан эрх зүйн актуудыг судалж үзвэл Монгол Улсын Засгийн газар өөрчлөгдөх болгонд тус их сургуулийн хуулийн этгээдийн нэршил өөрчлөгдөх, түүнчлэн Их сургуулийн дүрэм, бүтэц, орон тооны хязгаар, албан хэрэг хөтлөлтөд өөрчлөлт орж, улмаар боловсролын индекст өөрчлөлт орох, сургалтын хөтөлбөрт өөрчлөлт орох, цаашлаад сонсогч, суралцагчдын сурлагын чанарт сөргөөр нөлөөлөхөөр байна гэж үзэж байна. Үүнээс гадна гадаадын их, дээд сургуулиудын хамтын ажиллагааны хүрээнд тухайн сургуулиудаас манай сургуульд хандахад хүртэл тодорхой хэмжээгээр хүндрэл учирдаг жишээ гарсаар байна. Гэтэл гадаадын их, дээд сургуулиудын хуулийн этгээдийн нэрийг ойр ойрхон өөрчлөх тохиолдол төдийлөн ажиглагддагүй

[7]Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем https://www.legalinfo.mn/law/details/2372?lawid=2372
[8]Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем https://www.legalinfo.mn/law/details/8763?lawid=8763
[9] Мөн тэнд https://www.legalinfo.mn/law/details/12099?lawid=12099
[10] Мөн тэнд https://www.legalinfo.mn/law/details/14309?lawid=14309

бөгөөд үйл ажиллагаа, статусын хувьд өргөжиж дээд сургуулиас академи, академаас их сургууль болон өөрчлөгддөг зүй тогтолтой.

Дүгнэлт

1. Сургуулийн нэр өөрчлөгдсөнөөр сургалтын хөтөлбөрийн индекст өөрчлөлт орж үл ойлголцол үүсэх магадлалтай. Жишээ татвал, 2012 онд Дотоод хэргийн их сургуулийн нэрийг Хууль сахиулахын их сургууль болгон өөрчилснөөр "Цагдаа-хууль сахиулах ажил", "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх-хууль сахиулах ажил" гэх сургалтын хөтөлбөрүүдийг батлуулсан байдаг. Мэдээж үзэл бодлын хувьд цагдаагийн байгууллага, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагад ажиллах мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэх нь зөв юм. Гэтэл шилжилтийн хөтөлбөр гэж нэрлэгдсэн хөтөлбөрөөр суралцаж судлах ёстой байсан хичээлээ судалдаггүй, эсхүл бүрэн хамрагдаж чаддаггүй г.м. Түүнчлэн, "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх-хууль сахиулах ажил" мэргэжлээр төгссөн төгсөгчид бусад их дээд сургууль, гадаадын их дээд сургуулийн магистрантурт элсэн суралцах боломжгүй бөгөөд хууль сахиулах гэх мэргэжил нь тухайн сургуулиудын тавигдах шаардлагад тохирдоггүй байдал ажиглагдсаар байна. Гадаад оронд ийм жишиг байгаа эсэхийг судлан үзвэл ОХУ-ын ДХЯ-ны сургуулийн төгсөгчид "Правоохранительная деятельность" буюу "хууль сахиулах" гэх мэргэшлээр төгсдөг хэдий ч үндсэн мэргэжлийн чиглэл нь эрх зүй байдаг онцлогтой байна.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн хэрэгжүүлж байгаа "Шүүхийн шийдвэр гүйцэтгэх-хууль сахиулах" хөтөлбөрөөр суралцаж төгссөн төгсөгчдид захиалагч байгууллагын зохих албан тушаалд ажиллахад ажлын байрны тодорхойлолтод заасан тавигдах шаардлагад нийцдэггүй. Тухайлбал, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх албаны шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, нэгжид ажиллах ахлах шийдвэр гүйцэтгэгч, шийдвэр гүйцэтгэгчийн ажлын байрны тодорхойлолтод эрх зүйч байхаар, хорих байгууллагын харуул хамгаалалт, аюулгүй байдлын чиг үүрэг бүхий алба хаагчдын ажлын байрын тодорхойлолтод эрх зүйч байхаар тус тус заасан байдаг. Энэ нь сургалт-практик зөрчилдөхөд хүргэж байна.

3. Сургуулийн нэр өөрчлөгдөх бүрт сургуулийн билэг тэмдэг, гадна талбайд байрлуулах нэр, албан бланк, сонсогч, суралцагчдын дүрэмт хувцасны таних тэмдэг, алба хаагчдын үнэмлэх зэргийг өөрчлөх шаардлага гардаг нь жилийн төсөвт суугаагүй тооцоолоогүй зардлыг гаргаж, санхүү

эдийн засгийн асуудал үүсгэдэг. Түүнчлэн Төсвийн тухай хууль тогтоомжоор тухайн жилийн төсөв хуулиар батлагдах үед хуулийн этгээдийн нэрээр батлагдсан байдаг бөгөөд хуулийн этгээдийн нэр өөрчлөгдсөн үед төсвийн мөнгийг зарцуулахад хүндрэл үүсдэг.

4. Ард иргэдийн дунд төөрөгдөл үүсэхээс гадна чухам аль сургуулийг нэрлээд байгаад төдийлөн ойлголт байдаггүй. Цагдаагийн академи, Хууль сахиулахын их сургууль гэсэн нэрээр ойлгож байдаг. Мөн шинээр элсэгчдийн хувьд элсэх сургуулийн нэр, сургалтын хөтөлбөрийн индекс жил бүр өөрчлөгдсөнөөр төөрөгдөл үүсдэг. Их сургуулийн нэршлийн хувьд сонирхолтой баримт сонирхуулад 2009 онд элсэгчид суралцах хугацаандаа 3 сургуульд суралцсан байдаг. Тухайн үед тус сургуульд элсэхдээ Цагдаагийн академид, суралцах хугацаандаа Дотоод хэргийн их сургуульд харин төгсөхдөө Хууль сахиулахын их сургуулийг төгссөн байх жишээтэй.

5. Дотоод хэргийн их сургуулийн дүрэм, бүтэц, орон тооны хязгаарыг хэт ойр ойрхон өөрчлөх нь давуу талтай гэхээсээ илүүтэйгээр сул тал ихтэй, их сургуулийн үйл ажиллагаанд нь сөргөөр нөлөөлөх, бодлогын хэрэгжилтэд гажуудал гарах, бэлтгэж буй хүний нөөцийн мэдлэг чадварт сөргөөр нөлөөлөх, багшийн ажлын ачаалал, механик ажилбар ихсэх, алба хаагч, багш судлаачдын ажилдаа хандах хандлага, идэвх сулрах нөхцөл үүсдэг гэж үзэж байна.

6. Тус Их сургуулийн захирал нь их сургуулийн багш, алба хаагчдыг томилох, чөлөөлөх эрхтэй хэдий боловч тэдэнд цагдаагийн цол болон цэргийн цол олгох, дүрэмт хувцас олгох эрх олгогдсон эрх зүйн зохицуулалт байхгүй нь учир дутагдалтай байна. Өөрөөр хэлбэл, цол олгуулах, цол бууруулах асуудлыг тухайн төв байгууллагын даргад уламжилж шийдвэрлүүлж байгаа нь эрх зүйн чадамжгүй менежер гэж үзэхээр байна. Түүнчлэн тус их сургуулийн багш, алба хаагчид нь цагдаа, хил, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын байгууллагуудын дүрэмт хувцас, цол хэрэглэж байгаа хэдий ч Цэргийн албаны тухай хууль Цагдаагийн албаны тухай хууль, Монгол Улсын Хилийн тухай хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, Гамшгаас хамгаалах тухай хуульд заасан үндэслэл, журмын дагуу эрх зүйн байдал, нийгэм, эдийн засгийн баталгаагаар хангагдахгүй байгаа нь тухайн багш, алба хаагчдын эрх зүйн байдлыг дордуулж байна.

7. Дотоод хэргийн их сургуулийн дүрмын 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсэгт "Их сургуулийн багш, ажилтан нар нь төрийн тусгай алба хаагч

байна" гэж заасан хэдий ч бусад төрийн тусгай байгууллагын алба хаагчийн эрх зүйн байдал, нийгэм, эдийн засгийн баталгаатай харилцан адилгүй байгаагаас үүдэн тус их сургуульд ажиллахыг төдийлөн сонирходоггүй байна. Гэтэл гадаадын улс оронд практик байгууллагад ажиллахаас илүүтэйгээр их, дээд сургуулиудад ажиллах сонирхолтой байдаг байна.

Иймд дээр дурдсан үндэслэл, журмыг судалж үзээд Дотоод хэргийн их сургуулийн эрх зүйн орчин боловсронгуй болгох зорилгоор дараахь саналыг дэвшүүлж байна.

1. Хууль зүй, дотоод хэргийн яамны харьяа Дотоод хэргийн их сургуулийн статусыг тодорхой болгож, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болгох;

2. Гадаадын ижил чиг үүрэг бүхий их, дээд сургуулиудын туршлагыг судалж, Дотоод хэргийн их сургуулийн багш, алба хаагчийн эрх зүйн байдал, нийгмийн баталгаа, чиг үүргийг тодорхойлсон бие даасан хуультай болгох. Ийнхүү Дотоод хэргийн их сургууль бие даасан хуультай болсоноороо удирдах алба хаагчийг томилох, чөлөөлөх эрх зүйн зохицуулалт нь тодорхой болохоос гадна багш, алба хаагчдын эрх зүйн болон нийгмийн баталгаа, ажиллах орчин нөхцөл бүрэн хангагдах боломж бүрдэнэ гэж үзэж байна.

ХОРИХ ГАЗРААС СУЛЛАГДСАН ХҮНИЙГ ЭРГЭН НИЙГЭМШҮҮЛЭХЭД АНХААРАХ АСУУДАЛ



Б.АЛТАНГЭРЭЛ
Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлал судалгааны профессорын багийн ахлагч, хууль зүйн ухааны доктор /Ph.D/, дэд профессор, хурандаа

Товч агуулга. Энэхүү илтгэлээр хорих газраас суллагдсан хүнийг нийгэмшүүлэх ажлын өнөөгийн нөхцөл байдал, түүний онцлог, анхаарах асуудал болон цаашдын зохион байгуулалтад анхаарах асуудлын талаар судалгаанд үндэслэсэн саналыг гаргахыг зорьлоо.

Abstract: The presentation aims to offer an assessment based ideas on the current practice of social reintegration of released inmates, its features, current challenges and future issues on implementations.

Нэр томьёо. Хорих ял эдлүүлэх ажиллагаа, хоригдлыг нийгэмшүүлэх ажлын онцлог, хоригдлын сэтгэл зүй, хорих ялын онцлог

Key words: Enforcements of custodial sentences, characteristics of social reintegration of inmates, inmate psychology, characteristics of custodial sentences

Гадаад орнуудын туршлагаас харахад ялын сонгох хувилбарын хүрээг тэлж өргөжүүлэхийн тулд юуны өмнө тухайн орны эрүүгийн болон ял, шийтгэл гүйцэтгэх ажиллагааны тухай хуульд[1] нийгмээс тусгаарлахгүй ялыг[2] түлхүү тусгасан байх ба эдгээр арга замын нэг нь "нийгмээс тусгаарлахгүйгээр оноох ял шийтгэл"-ын нэг төрөл буюу буюу "хорих ялын гүйцэтгэлийг хойшлуулах, хугацаанаас өмнө суллах" тухай ойлголт юм.

Уг ялыг тухайн этгээдийн зан үйл, ёс суртахууны төлөвшил, үйлдсэн гэмт хэргийн төрөл, нийгэмд учруулсан сөрөг үр дагавар, хохирлын хэмжээ, гэм буруугийн хэлбэр зэрэг олон хүчин зүйлсийг харгалзаж оногдуулдаг ба хүнлэг ёсны үзэл санаа давамгайлсан, ялтныг эргэн

[1] Монгол Улсын хувьд уг хуулийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай гэж нэрлэсэн байна.
[2] Монгол Улсын хувьд уг ялыг "хорихоос өөр төрлийн ял" гэж нэрлэсэн байна.

нийгэмшүүлэх боломжтой, эдийн засгийн хувьд хэмнэлттэй зэрэг давуу талуудыг дурдаж болно.

Олон улсын ял эдлүүлэх салбарт өргөнөөр хэрэглэгдэж буй социализация (орос), socialization (англи), sozialisierung (герман), ресоциализация, resocialization, resozialisierung, реабилитация, rehabilitation, social rehabilitation, rehabilitierung, sozialerehabilitierung, коррекция, исправление, адаптация гэсэн үг хэллэг-нэр томьёогоор илэрхийлэгдсэн "хоригдлыг нийгэмшүүлэх", "хоригдолд нийгмийн ажлын, сэтгэл зүйн, сэтгэц заслын үйлчилгээ үзүүлэх", "хоригдолд эрх зүйн нийтлэг журамд хүндэтгэлтэй хандах харьцааг төлөвшүүлэх", "хоригдлыг суллагдсаны дараа бие даан амьдрах дадал, чадварт сургах" зэрэг нэр томьёо тусгагдан хэрэгжиж байна.

Түүнчлэн гэмт хэрэг үйлдсэн этгээдийг "нийгэмшүүлэх" гэж ярихаас гадна энэ үйл ажиллагаанд "эргэн /өөрчлөн/ нийгэмшүүлэх" гэсэн нэр томьёог ашиглах нь нийгэмшүүлэх ажлын агуулгыг бүрэн дүүрэн илэрхийлнэ гэж үздэг байна.

Монгол Улс дахь ял эдлүүлэх ажиллагааны өнөөгийн байдлаас харахад гэмт хэрэг үйлдэж, хорих ял эдлэгсдийн тоо жилд дунджаар 8.3-15.2 хувиар өссөн үзүүлэлттэй[3], хорих ял эдлээд суллагдсан иргэдийн зүгээс давтан гэмт хэрэг үйлдэх явдал буурахгүй[4], байна. Энэхүү статистик үзүүлэлтээс гадна ял эдэлж буй хоригдлыг хорих байгууллагаас суллагдсаны дараа үзүүлэх нийгэмшүүлэх ажлын тогтолцоо хангалтгүй, хууль сахиулах байгууллагуудын хэмжээнд эрх зүйн зохицуулалтын хувьд хүлээсэн чиг үүрэг бүрэн тодорхойлогдоогүй байгаа нь эрх зүйн зохицуулалтын болон зохион байгуулалтын шинэлэг арга хэлбэр шаардлагатайг илэрхийлж байгаа юм.

Давтан гэмт хэргийг бууруулах, нийгмийн дэг журам, ялын гүйцэтгэлийн зорилгыг бүрэн хангахад хорихоос суллагдсан хүнд тавих хяналт, тэднийг нийгэмшүүлэх нь хамгийн чухал асуудал болоод байна.

Ял эдлүүлэх ажиллагааны гол зорилго нь гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэх, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх замаар нийгэмд шударга байдлыг тогтооход оршино.Эрүүгийн ял, шийтгэлийг

[3]ШШГЕГ-ын Хорих ял эдлүүлэх албаны 2009-2017 оны тайлангаас үзэхэд жилийн эцсийн байдлаар нийт 5069-7083 ялтан ял эдэлж байжээ.

[4]2016 оны жилийн эцсийн дүнгээр нийт ял эдэлж буй хоригдогсдын 32 хувь нь 2-3 удаа гэмт хэрэг үйлдсэн, 16 хувь 4-ээс дээш удаа давтан гэмт хэрэг үйлдсэн байна.

тодорхойлсон эрх зүйн зохицуулалт болон ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилтэд тулгуурлан ялын гүйцэтгэлийн бодлого тодорхойлогдох бөгөөд эрүүгийн ялын бодлогыг түшиглэн төрийн эрүүгийн бодлого бүрдэнэ.

Эрүүгийн ялын гүйцэтгэлийн бодлого гэдэгт төрийн зүгээс эрүүгийн ял шийтгэлийн зорилгыг тодорхойлох, эрх зүйн тогтолцоог бүрдүүлэх, ял, шийтгэлийн хэрэгжилтийг хангах болон шүүхээс ял оноосон этгээдийг нийгэмшүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээг ойлгох ба дараах чиг үйл ажиллагааг гүйцэтгэнэ.Үүнд:

1. Эрүүгийн ялыг гүйцэтгэх ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай орчин нөхцөлийг бүрдүүлэх;

2. Эрүүгийн ялыг гүйцэтгэх ажиллагааны хууль тогтоомжийг олон улсын стандартад нийцүүлэх (хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгох);

3. Гэмт хэрэг үйлдсэн этгээдийг сургаж хүмүүжүүлэх, хорих газраас суллагдсан хүнийг эргэн нийгэмшүүлэх зэрэг болно[5].

Хорих байгууллагаас суллагдсан хүнийг нийгэмшүүлэх ажиллагааны онцлог, анхаарах асуудал

Хорих ялтай холбоотой нийгэмшүүлэх ажлыг өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж буй эрх зүйн зохицуулалтын хүрээнд:

а/ Хорих ял эдлүүлэх ажиллагааны хүрээнд явагдаж буй нийгэмшүүлэх ажил нь 2017 оны 7 дугаар сарын 01-ны өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 218, 219 дүгээр зүйл, 2018 оны 7 дугаар сарын 03-ны өдрийн Нийгмийн ажлын аргачилсан заавар;

б/ Хорих ял оногдуулахгүйгээр тэнссэн, хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоолыг биелүүлэхийг хойшлуулсан болон хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоосон шийдвэрийг биелүүлэх үеийн хяналтыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 185-189 дүгээр зүйл;

в/ Шүүхээс оногдуулсан хорих ялын хугацаа дуусч суллагдсан этгээдийн хяналтыг Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 9 болон 41-45 дүгээр зүйлийн хүрээнд зохицуулж байна.

---

[5] Б.Алтангэрэл.Хорихоос өөр төрлийн ял эдлүүлэх ажиллагаа:харьцуулсан судлал.УБ.,2018.19 дэх тал

Хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн хүрээнд суллагдсан этгээдтэй холбоотой эрх зүйн зохицуулалт нь "хяналт"-аар хязгаарлагдаж буй нь тэднийг хэн, хэрхэн нийгэмшүүлэх асуудлыг орхигдуулжээ.

Дэлхийн ихэнхи оронд хорих ял эдлээд суллагдсан этгээдэд үзүүлэх нийгэмшүүлэх ажлыг тухайн иргэнийг нийгмийн харилцаанд оролцогч гэдэг утгаар нь дараах үндсэн хэлбэрүүдээр явагдаж байна.

1.Нийгмийн харилцаанд эрх зүйн дэг журмыг мөрддөг, бие даан амьдрах чадвартай иргэн болгон төлөвшүүлэхэд чиглэгдсэн амьдрах ухааны болон боловсрол, мэргэжил, хөдөлмөрийн дадлага олгох "СУРГАЛТ"-ад хамруулах;

2. Тухайн хүний ур чадвар, хүсэл, сонирхлыг харгалзан тогтвортой ажлын байраар хангахад чиглэсэн "ЗУУЧЛАХ" үйлчилгээг явуулах;

3. Суллагдсан хүний хувийн болон санхүү, гэр бүлийн байдал зэргийг харгалзан "НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН" үйлчилгээнд хамруулах зэрэг болно.

Дээрх ажил үйлчилгээнд суллагдсан этгээдийг тэгш хүртээмжтэй хамруулснаар нийгэмшүүлэх ажлын үр дүн нэмэгдэн, дахин гэмт хэрэг буурах, улмаар хүний эрх, эрх чөлөө бүрэн утгаар хангагдах учиртай.

Монгол Улсын хэмжээнд хорих ялтай холбоотой ялын гүйцэтгэлийг хойшлуулсан, тэнссэн, хугацаанаас өмнө сулласан судалгааг сүүлийн 5 жилээр авч үзвэл:

1. Шүүхээс 2014 онд 6277 хүнд хорих ял оногдуулснаас 2441 хүнд биечлэн эдлүүлж, 3396 хүнийг тэнсэн, 434 хүнийг тогтоол биелүүлэхийг хойшлуулсан, 2015 онд 5257хүнд хорих ял оногдуулснаас 2070 хүнд биечлэн эдлүүлж, 3197 хүнийг тэнсэн, 365 хүнийг тогтоол биелүүлэхийг хойшлуулсан, 2016 онд 5114 хүнд хорих ял оногдуулснаас1823 хүнд биечлэн эдлүүлж, 2866 хүнийг тэнсэн, 303 хүнийг тогтоол биелүүлэхийг хойшлуулсан, 2017 онд нийт 4596 хүнд хорих ял оногдуулснаас 2192 хүнд биечлэн эдлүүлж, 2045 хүнийг тэнсэн, 310 хүнийг тогтоол биелүүлэхийг хойшлуулсан, 2018 онд нийт 3245 хүнд хорих ял оногдуулснаас 2995 хүнд биечлэн эдлүүлж, 132 хүнийг тэнсэн, 111 хүнийг тогтоол биелүүлэхийг хойшлуулсан[6] судалгаа байна.

2. Хорих байгууллагаас 2014 онд-2065 хоригдол суллагдсанаас: хугацаа дууссч-440 нь, хугацаанаас өмнө-1585, ерөнхийлөгчийн зарлиг,

[6] Б.Алтангэрэл.Монгол Улсын хорих ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ 2003-2018.Уб.,2019 он.59 дэх тал

ялын өөрчлөлт, өвчний учир-40, 2015 онд-3445 хоригдол суллагдсанаас: хугацаа дуусч-428, хугацаанаас өмнө-1167, өршөөлийн хуулиар-1778, ерөнхийлөгчийн зарлиг, ялын өөрчлөлт, өвчний учир суллагдсан-72, 2016 онд-1334 хоригдол суллагдсанаас: хугацаа дуусч-310, хугацаанаас өмнө-997, өршөөлийн хуулиар-6, ерөнхийлөгчийн зарлиг, ялын өөрчлөлт, өвчний учир суллагдсан-21, 2017 онд-2918 хоригдол суллагдсанаас: хугацаа дуусч-396, хугацаанаас өмнө-1115, хуулийн тэгшитгэлд-1342, ерөнхийлөгчийн зарлиг, ялын өөрчлөлт, өвчний учир суллагдсан-65, 2018 онд-1813 хоригдол суллагдсанаас: хугацаа дуусч-702, хугацаанаас өмнө-1068, хуулийн тэгшитгэлд-20, ерөнхийлөгчийн зарлиг, ялын өөрчлөлт, өвчний учир суллагдсан-23 хүн тус тус суллагдаж байсан байна[7].

Кейс.1.Эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч О... Монгол Улсын хэмжээнд суллагдсан хүнийг нийгэмшүүлэх асуудал нь зөвхөн захиргааны хяналтын хүрээнд явагдаж байгаа, Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтсийн ажилтан Б...суллагдсан хүнтэй сард 1 удаа уулзаж бүртгэл хөтөлдөг.

Монгол Улсын өнөөгийн практикт хугацаанаас өмнө суллах, тэнсэх, ял хойшлогдсон хүнд тавих хяналт, нийгэмшүүлэх ажлыг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, хорих ялын хугацаа дуусч суллагдсан хүнд тавих хяналт, нийгэмшүүлэх асуудлыг Цагдаагийн байгууллага хариуцан гүйцэтгэж байна.

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн сайд, Сангийн сайдын 2017 оны 9 дүгээр сарын 23-ны өдрийн А/247, А/167/303 дугаар хамтарсан тушаалаар хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг хэрэгжүүлэх шийдвэр гүйцэтгэгч нийслэлд 160, орон нутагт 120 ялтан, этгээдэд холбогдох гүйцэтгэх хуудсанд хяналт тавиж ажиллахаар жишиг нормативийг батлан тогтоосон. 2019 оны байдлаар 1 эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч орон нутагт 250, нийслэлд 360 этгээдэд хяналт тавин ажиллаж байна.

Эндээс харахад суллагдсан хүнийг нийгэмшүүлэх нь зөвхөн дахин гэмт хэрэг үйлдэж болзошгүй гэсэн үндэслэлээр дуудаж уулзах, хянах байдлаар явагдаж байна.Өөрөөр хэлбэл "ХЯНАЛТ-НИЙГЭМШҮҮЛЭХ АЖИЛ"-ын харьцаа алдагдсанаар суллагдсан этгээдийг эргэн нийгэмшүүлэх ажил үр дүнтэй явагдахгүй байна.

[7] Хоригдогчдын шилжилт, хөдөлгөөн, дүн бүртгэлийн тасгийн тайлан, мэдээ

Түүнчлэн суллагдсан этгээдийг нийгэмшүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагаа, оролцоог хуульчилсан эрх зүйн зохицуулалт хангалтгүй, гэмт хэрэг үйлдсэн этгээдийг нийгэмшүүлэхтэй холбоотой Цагдаагийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага тус тусдаа өөр өөрсдийн хууль, журам, зааврын хүрээнд гүйцэтгэгдэгээс болж байна.

Улс төр, эдийн засаг, нийгмийн бүхий л салбарууд, тэр дундаа хууль зүйн салбарт хийгдэж буй тогтолцооны болон эрх зүйн шинэчлэл, өөрчлөлтүүд нь хүний хөгжлийг, улмаар нийгмийн зөв тогтолцоог дэмжин хөгжүүлэхэд чиглэгдсэн байх ёстойг бүх нийтээр хүлээн зөвшөөрч байна.

Хоригдлыг хорих байгууллагаас суллагдсаны дараа үзүүлэх нийгэмшүүлэх ажлын тогтолцоо байхгүй, хууль сахиулах байгууллагуудын хэмжээнд эрх зүйн зохицуулалтын хувьд хүлээсэн чиг үүрэг бүрэн тодорхойлогдоогүй, хэрэгжүүлэх нэгдсэн тогтолцоогүй байгаа нь бие даасан эрх зүйн зохицуулалтын болон бүтцийн шинэлэг арга хэлбэр шаардлагатайг илэрхийлж байгаа юм.

Өөрөөр хэлбэл, ял эдлүүлэх ажиллагааны тогтолцоо, хэлбэр, эрх зүйн зохицуулалтыг Монгол Улсын нийгэм, эдийн засгийн хөгжил, хүн амын өсөлт, гэмт хэргийн гаралт, нөхцөл байдалтай холбон өөрчлөх, гадаадын бусад орны ижил чиг үүрэг бүхий байгууллагын үйл ажиллагааны туршлагад суурилан, олон улсын чиг хандлага, загварт нийцүүлэн хөгжүүлэх нь зүйтэй юм.

Илтгэлийн хүрээнд Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 40 эрүүгийн шийдвэр гүйцэтгэгч нараас суллагдсан иргэнд тавих хяналт, нийгэмшүүлэх ажлын үр дүнгийн талаар судалгаа авахад сайжруулах шаардлагатай гэж 60 хувь, шаардлага хангахгүй байна гэж 35 хувь нь үзсэн нь хангалтгүй байгааг илтгэн харуулж байна.

Иймд суллагдсан хүнийг эргэн нийгэмшүүлэхтэй холбоотой дараах саналыг гаргаж байна.

1. Дэлхийн улс орнуудад хэрэглэгдэж буй хорих ял хойшлогдсон, суллагдсан зэрэг хүнийг нийгэмшүүлэх чиг үүрэг бүхий "Пробаци"-ын албаны үйл ажиллагааг Монгол Улсад нэвтрүүлэх.

2. Улс орны хэмжээнд нийгмийн ажлын ерөнхий хуулийг батлан, тухайн хуульд хорих ял эдлээд суллагдсан хүнийг нийгэмшүүлэх асуудлыг хуульчлах.

3. Суллагдсан хүнийг нийгэмшүүлэхэд зөвхөн төрийн байгууллагын хүчээр бус хувийн хэвшил, иргэдийн оролцоо нэн чухал гэдэгтэй санал нийлэн, энэ хүрээнд хууль тогтоомж, зохион байгуулалтын арга хэмжээ авах зэрэг болно.

ХАР ТАМХИНЫ ТӨРЛИЙН ГЭМТ ХЭРЭГ ҮЙЛДСЭН ХОРИГДЛУУДТАЙ АЖИЛЛАХАД АНХААРАХ АСУУДАЛ



Г.ТАМИР
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа 421 дүгээр нээлттэй хорих ангийн дарга, хурандаа

Товч агуулга: Монгол Улсад сүүлийн жилүүдэд мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэргийн гаралт эрчимтэй нэмэгдэж аюулын харанга дэлдэж байна. Цаашдаа ч энэ төрлийн гэмт хэргийн гаралт өсөх төлөвтэй. Хорих байгууллагад энэ төрлийн гэмт хэрэг үйлдэж хорих ял эдлэгчдийн тоо өссөөр байна. Одоогоор хорих ял эдлэгсдийн дотор мансууруулах бодист донтогч байхгүй боловч ирээдүйд ийм этгээд ял эдлэх нь тодорхой. Иймд хар тамхинд донтогч, идэвхтэй хэрэглэгч хоригдлуудтай хэрхэн ажиллах тухай бэлтгэлийг нэн яаралтай хангах талаар санал дүгнэлт дэвшүүлсэн.

Abstract: In recent years, the prevalence of crimes related to the illegal flow of drugs and controlled substances has progressively increased and is becoming a threat in Mongolia. In the future, this kind of crime is expected to grow and the number of inmates who commit such crimes is increasing. Although currently there are no inmates who are addicted to drugs, in the future, it is expected that a subject who abuses drugs might be sentenced to serve in prison. Thus, we have urgently put forth recommendations regarding preparation for working with inmates who are addicted to and actively abuse drugs.

Түлхүүр үг: Мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл, хар тамхи, хорих ял эдлүүлэх ажиллагаа, албадан эмчилгээ, сургалт, нийгэмшүүлэх ажил, сэтгэл заслын үйлчилгээ

Key words: narcotics, substances that affect mental health, drugs, imprisonment operations, forced treatment, training, rehabilitation work, mental treatment services.

Сүүлийн жилүүдэд мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн хууль бус эргэлт, түүнтэй холбоотой гэмт хэргийн гаралт

эрчимтэй нэмэгдэж, энэ нь манай улсын үндэсний аюулгүй байдалд нөлөөлж болзошгүй байна. Тухайлбал: 1986-2012 он хүртэл 26 жилийн хугацаанд дээрх төрлийн 67 гэмт хэрэгт 157 хүн ял шийтгүүлсэн байдаг. Гэтэл сүүлийн 5 жилд энэ төрлийн 553 гэмт хэрэг бүртгэгдэж олон тооны этгээдүүд шалгагджээ [1] /график-1/. Монгол Улсын шүүн таслах ажиллагааны 2018 оны тайлан[2]-аас үзвэл 2016 онд 74 хэрэгт 138 хүн, 2017 онд 85 хэрэгт 85 хүн, 2018 онд 128 хэрэгт 113 хүн ял шийтгүүлсэн байна. /график-2/

Улсын хэмжээнд бүртгэгдсэн нийт гэмт хэргийн үйлдэгдсэн байдлыг сүүлийн 3 жилийн байдлаар авч үзвэл: 2016 онд мансуурсан 65, согтуугаар 5520, 2017 онд мансуурсан 92, согтуугаар 4012, 2018 онд мансуурсан 176, согтуугаар 3286, 2019 оны эхний 6 сарын байдлаар мансуурсан 110, согтуугаар 1887 гэмт хэрэг тус тус үйлдэгдсэн тухай мэдээ байна. /график-3/

Мөн дээрх төрлийн гэмт хэрэгт 2015 оны жилийн эцсийн байдлаар 18, 2016 онд 52, 2017 онд 32, 2018 онд 65, 2019 оны 7 сарын байдлаар 91 хүн хорих ял эдэлж байна[3]. /график-4/ Одоо ял эдэлж 91 хүний 67,3 хувь нь анх удаа, 32,7 хувь нь энэ төрлийн гэмт хэргийг давтан үйлдэгч байна. Үүнээс гадна тухайн гэмт хэрэгт шалгагдан цагдан хоригдож буй 84 хоригдогч өнөөдрийн байдлаар байна. Тэдний олонх буюу 94 хувь нь 19-40 насны буюу залуучууд байна. /график-5/

Гадаад улсад 2006 оноос 2015 оны хооронд манай улсын 126 иргэн хар тамхитай холбоотой гэмт хэрэгт холбогдсон бөгөөд үүнээс тээвэрлэсэн 13, хадгалсан 15, хилээр нэвтрүүлсэн 41, хэрэглэсэн 39, бусдад дамжуулсан 1 иргэн тус тус тухайн орны шүүхээс ял шийтгэгдсэн бол 2016 онд 18 иргэн энэ төрлийн гэмт хэрэгт холбогдон шалгагдсан байна.

Манай орны зарим нутаг дэвсгэрт ургадаг мансууруулах болон донтуулах үйлчилгээтэй бодис бүхий ургамал болох намуу, зэрлэг олс, зээргэнэ, лантанз зэрэг 9 овог, 11 төрөлд хамаарах 18 зүйл ургамал нь манай улсын 14 аймгийн 49 гаруй сумын нутаг дэвсгэрт 15,000 орчим га талбайд ургадаг гэсэн судалгаа байдаг[4].

---

[1] http://police.gov.mn/home ЦЕГ-ын цахим мэдээлэл

[2] Монгол Улсын 2018 оны шүүн таслах ажиллагааны тайлан. Шүүхийн ерөнхий зөвлөлийн цахим хуудас. www.judinstitude.mn

[3] ШШГЕГ-ын хорих ял эдлүүлэх албаны 2019 оны 07-р сарын статистик мэдээ

[4] Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоолын хавсралт

Монгол Улсын Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн судалгаагаар[5] сүүлийн жилүүдэд мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл хэрэглэгч болон түүнд донтогчийн тоо өсөн нэмэгдэх хандлагатай байна.

Дээрх тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийж үзвэл манай улсад мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэлийн хууль бус эргэлт, түүнтэй холбоотой гэмт хэргийн гаралт, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл /цаашид мансууруулах бодис гэх/ хэрэглэгчийн тоо цаашид тогтвортой өсөхөөр байна.

Энэ төрлийн гэмт хэргийн гаралт, хэрэглэгчийн тоо өсөх болсон шалтгааныг улс орны гадаад дотоод олон хүчин зүйлтэй холбон тайлбарлаж болно. Тухайлбал: Хөрш хоёр улс мансууруулах бодисын хууль бус эргэлт, хэрэглээгээр өндөрт тооцогддог, иргэдийн улс хооронд харилцан зорчих явдал, арилжаа худалдаа, мэдээлэл солилцоо улам бүр өссөн зэрэг даяаршлын болон иргэдийн ухамсар, нийгэм хүн ам зүйн олон хүчин зүйлийг дурдаж болно.

Сүүлийн жилүүдэд амфетамин, метамфетамины төрлийн болон мансууруулах ургамлын гаралтай бодисыг Монгол Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн, нэвтрүүлэхийг завдсан, зарж борлуулсан гэмт хэрэг, зөрчлийн тоо ихсэх болсон.[6]

Өнөөдрийн байдлаар мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг үйлдэж хорих ял эдэлж буй нийт хоригдлын 70 гаруй хувь нь мансууруулах бодисыг сонирхон хэрэглэгч байна. Нийт хорих ял эдлэгчдийн дунд хийсэн судалгаагаар мансууруулах бодис идэвхтэй хэрэглэгч буюу донтогч одоогоор байхгүй байна.

ШШГЕГ-ын харьяа Согтуурах, мансуурах донтой өвчтөнийг албадан хөдөлмөр хийлгэх газарт захиргааны журмаар албадан эмчлүүлсэн мансуурах донтой этгээд одоогоор байхгүй. Гэвч мансууруулах бодист хэт хамаарал бүхий /донтогч/ хоригдол байхгүй гээд тайвширч болохгүй. Өөрөөр хэлбэл мансуурах бодист хэт хамаарал бүхий хоригдлуудтай хэрхэн ажиллах, тэднийг хэрхэн эмчилж нийгэмшүүлэх, хорих ангийн харуул хамгаалалтын үйл ажиллагааг хэрхэн зохион байгуулах, хорих ангид мансууруулах бодис нэвтрэхээс яаж урьдчилан сэргийлэх, мансууруулах бодисыг таньж илрүүлэх, түүнд зориулсан техник хэрэгсэл

[5] Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2018 оны статистик мэдээ, СЭМҮТөв
[6] Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 77 дугаар тогтоолын хавсралт

ашиглах ур чадварыг алба хаагчиддаа эзэмшүүлэх, мансуурсан хоригдолтой хэрхэн ажиллах зэрэг тулгамдсан олон асуудалд одооноос эхлэн бэлтгэх шаардлагатай байна. Түүнчлэн мансуурах донтой этгээдэд үзүүлэх сэтгэл зүйн болон эмнэлгийн тусгайлсан үйлчилгээний арга технологийг хорих байгууллагад нэвтрүүлж хүний нөөцийг чадавхижуулах, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг дотоод гадаадын бусад байгууллагуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэх шаардлага тулгарч байна.

2017 онд Монгол Улсын засгийн газраас Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх үндэсний хөтөлбөрийг баталсан нь мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээ, түүнээс үүдэх гэмт явдалтай хийх тэмцэлд чухал нөлөөтэй арга хэмжээ болсон. Уг хөтөлбөрийг 2 үе шаттайгаар хэрэгжүүлэх бөгөөд 1-р үе шатанд /2017-2019 он/ мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй тэмцэх эрх зүйн орчинг боловсронгуй болгож, ажлын шинэ арга замыг тодорхойлох; мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодисын хор хөнөөлийг иргэдэд тайлбарлан таниулах, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимтэй, үр дүнтэй зохион байгуулах бол 2-р шатанд /2019-2021 он/ мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хууль бус эргэлттэй холбоотой гэмт хэрэгтэй тэмцэхэд шаардлагатай холбоо, харилцаа, техник, тоног төхөөрөмжийг шинэчлэх, хангах; мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын шалтгаант эмэгтэй болон мансуурсан хүнд сайн дурын болон албадан эмчилгээ, сэтгэл зүйн тусламж үзүүлэх, нийгэмшүүлэх үйлчилгээний төвийг байгуулах гэх мэт үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.

Хорих ял эдлүүлэх ажиллагааг зохицуулсан эрх зүйн гол эх сурвалж болох Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 208 дугаар зүйлд "...мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах гэмт хэрэг үйлдсэн хоригдлыг энэ төрлийн гэмт хэрэг үйлдсэн хоригдлоос тусад нь ял эдлүүлнэ гэж[7] заасан. Гэвч хуулийн энэхүү зохицуулалтыг бүрэн хэрэгжүүлэх, өөрөөр хэлбэл энэ төрлийн гэмт хэрэгт хорих ял эдэлж буй хоригдлуудыг хоорондоо огт харьцахгүй байхаар тус тусдаа ял эдлүүлэх орчин нөхцөлийг хараахан бүрдүүлж чадаагүй байна. Харин хорих байгууллагын зүгээс мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэгт ял шийтгүүлж хорих ял эдэлж буй этгээдийн сөрөг нөлөөллөөс бусад хоригдлыг хамгаалахад ихээхэн анхаарч ирсэн.

[7] Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль. Төрийн мэдээлэл эмхтгэл. 2017. №24

Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хэрэглээтэй холбоотой эрх зүйн хэм хэмжээ болон үндэсний хөтөлбөрт үндэслэн мансууруулах бодист хамаарал бүхий хоригдлуудын зан үйлд нөлөөлөхөд чиглэсэн "Сэтгэл хөдлөлөө хянах нь", "Гэр бүлийн харилцаа хандлага", "Зан төлөв, түүний онцлог", "Донтолт ба нойрны хямрал, "Уур бухимдалаа зохицуулах нь" зэрэг төрөл бүрийн сургалтуудыг төрийн болон төрийн байгууллагуудтай хамтран зохион байгуулж ирсэн.

Түүнчлэн бясалгалын сургалтад энэ төрлийн гэмт хэрэгт ял шийтгүүлсэн хоригдлуудыг хамруулсан зохих үр дүнгээ өгдөг.

Мансууруулах бодистой холбоотой гэмт хэрэг үйлдсэн хоригдлуудыг албадан сургалтад хамруулах тухай Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд[8] заасан боловч уг сургалтын хөтөлбөр, агуулга, сургалтын гарын авлага, сургалт зохион байгуулах хүний нөөц, хөрөнгө мөнгөний асуудал одоогоор нэг мөр шийдвэрлэгдээгүй.

Нөгөө талаас мансуурах донтой этгээдтэй хэрхэн ажиллах, тэдгээрийг эмчлэх, сэтгэл заслын үйлчилгээнд хамруулах, хорт зуршлаас нь салгах чиглэлээр Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв болон гадаад дотоодын бусад байгууллагуудтай хамтран ажиллах асуудлыг ихээхэн чухалчилж хүний нөөцөө чадавхижуулахад анхааран ажиллаж байна.

Монгол Улсын эрүүгийн хуульд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээг зөвхөн сэтгэцийн хувьд хэрэг хариуцах чадваргүй эсхүл ял эдлэх боломжгүй болсон хүмүүст оногдуулахаар заасан. Харин мансуурах донтой этгээдийг хорих ял эдлэх явцад нь албадан эмчлэх асуудал эрх зүйн зохицуулалтын хувьд хийдэлтэй байна.

Энэхүү илтгэл мэдээллийн хүрээнд дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд:

1. Мансуурах донтой, хар тамхинд хамаарал бүхий хоригдолд үзүүлж буй эмчилгээ, сэтгэл засал, нийгэмшүүлэх ажлын ололт амжилт, туршлагаа хуваалцах, харилцан мэдээлэл солилцох;

2. Дээрх чиглэлээр хүний нөөцийг чадавхижуулах, сургаж дадлагажуулахад харилцан дэмжлэг үзүүлэх зэрэг болно;

[8] https://www.legalinfo.mn/law/details/12701 Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, 2017

Хавсралт мэдээлэл

График-1



График-2



График-3



График 4



График 5



График 6



График 7



График 8



График 6





Хүснэгт 2

Мансууруулах болон сэтгэц идэвхит эм, бодис хэрэглэх донтой хэвтэн эмчлүүлсэн хүмүүс, оношоор **(СЭМҮТ)**

Он	Опиоидын шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд F11	Каннабиноидын шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд F12	Тайвшруулах, нойрны эмийн шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд F13	Кокайны шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд F14	Кофей н буюу бусад сэдээгч хэрэглэснээс үүссэн сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд F15	Хий үзэгдлийг үүсгэгч эм бодисын шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд F16	Дэгдэмхий уусгагч бодисын шалтгаант сэтгэцийн ба зан үйлийн эмгэгүүд F18	Олон төрлийн сэтгэц нөлөөт ба донтолт үүсгэх бодисыг хослуулан хэрэглэсний улмаас үүсэх сэтгэц болон зан үйлийн эмгэгүүд F19	Нийт
2014	5	7	16	0	1	2	0	6	37
2015	10	8	4	0	4	1	0	12	39

Хүснэгт 1

Мансууруулах болон сэтгэц идэвхит эм, бодис хэрэглэх донтой хэвтэн эмчлүүлсэн хүмүүс **(СЭМҮТ)**

Үзүүлэлт		2014		2015		2016		2017		2018	
		n	%	n	%	n	%	n	%	n	%
Хүйс	эрэгтэй	20	54.1	27	69.2	26	65.0	32	60.4	40	76.9
	эмэгтэй	17	45.9	12	30.8	14	35.0	21	39.6	12	23.1
Нас	10--19	5	13.5	3	7.7	7	17.5	15	27.3	14	26.9
	20-29	11	29.7	14	35.9	15	37.5	18	32.7	20	38.5
	30-39	4	10.8	11	28.2	7	17.5	9	16.4	11	21.2
	40-49	5	13.5	5	12.8	4	10.0	4	7.3	5	9.6
	50-59	6	16.2	6	15.4	2	5.0	3	5.6	2	3.8
	60+	6	16.2	0	0	5	12.5	6	10.9	0	0.0
Давтан хэвтэн эмчлүүлэгчийн тоо				3		3		3			0.0
Нийт		**37**	**100**	**39**	**100**	**40**	**100**	**55**	**100**	**52**	**100**

Он	2014	2015	2016	2017	2018
Опиоидын шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд F11	14	19	13	10	18
Каннабиноидын шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд F12	2	3	5	14	11
Тайвшруулах, нойрны эмийн шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд F13	22	9	9	9	17
Кокайны шалтгаант сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд F14	1	0	1	0	1
Кофейн буюу бусад сэдээгч хэрэглэснээс үүссэн сэтгэцийн болон зан үйлийн эмгэгүүд F15	1	3	7	5	3
Дэгдэмхий уусгагч бодисын шалтгаант сэтгэцийн ба зан үйлийн эмгэгүүд F18	5	5	2	21	19
Олон төрлийн сэтгэц нөлөөт ба донтолт үүсгэх бодисыг хослуулан хэрэглэсний улмаас үүсэх сэтгэц болон зан үйлийн эмгэгүүд F19	4	5	2	3	5
Нийт	49	44	39	62	74

2016	10	6	7	0	5	1	4	7	40
2017	11	8	9	0	5	0	5	17	55
2018	12	9	4	0	1	0	7	19	52

Хүснэгт 3

Мансууруулах болон сэтгэцэд хүчтэй нөлөөлөх эм, бодисын шалтгаант магадлагааны тоо	2014	2015	2016	2017	2018
	133	90	174	239	261

Хүснэгт 4

Мансууруулах болон сэтгэц идэвхит эм, бодис, бүртгэгдсэн өвчлөл,

(улсын дүнгээр)

ХОРИХ БАЙГУУЛЛАГЫН ХАРУУЛ ХАМГААЛАЛТАД ТЕХНИК, ТЕХНОЛОГИЙН ДЭВШЛИЙГ АШИГЛАХ НЬ



Ч.МӨНХ-ЭРДЭНЭ
Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорих ял эдлүүлэх албаны дэд дарга бөгөөд харуул хамгаалалт, аюулгүй байдлын хэлтсийн дарга, дэд хурандаа

Товч агуулга. Илтгэлийн хүрээнд Монгол Улсын хорих байгууллагын харуул хамгаалалтын үйл ажиллагаанд ашиглаж буй техник хэрэгслийн өнөөгийн байдал, тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга замын талаар өөрийн санал дүгнэлтийг гаргахыг зорьсон.

Abstract. Presentation is aiming to share own views and opinion on the current state and challenges of security equipment and devices used in Mongolian correctional units and proposing solutions

Түлхүүр үгс. Хорих байгууллага, харуул хамгаалалт, хоригдол, биечилсэн хяналт, техникийн хяналт, техник хэрэгсэл, дуу-дүрсний бичлэг.

Keywords. Correctional unit, guard and security, inmates, direct supervision, technical supervision, equipment and devices, audio-video footage.

Монгол Улсын хорих байгууллага нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын хуулиар хүлээсэн үндсэн чиг үүргийн нэг болох яллагдагчийг цагдан хорих таслан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, хорих ял шийтгэгдсэн этгээдэд оногдуулсан ялыг албадан эдлүүлэх, тэднийг нийгэмшүүлэх, аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Монгол Улсын хэмжээнд 2018 онд үйлдэгдсэн нийт гэмт хэрэг 1968 он буюу 50 жилийн өмнөхтэй харьцуулахад 10 дахин, 2003 онтой харьцуулахад 1,8 дахин өссөн нь хорих ял шийтгэгдэгсдийг нийгэмшүүлэх, харуул хамгаалалтыг чанд зохион байгуулж, аюулгүй байдлыг хангах, давтан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх шаардлагатайг харуулж байна.

Хорих байгууллагын харуул хамгаалалт, аюулгүй байдлын алба нь хоригдогч, хоригдлыг оргон зайлах, хорих ангийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулж болохуйцаар эмх замбараагүй байдал бий болгох, өөрийн болон бусдын амь нас, эрүүл мэндэд хохирол учруулах зэрэг гэмт үйлдлээс урьдчилан сэргийлэх, таслан зогсоох чиг үүргийг хэрэгжүүлдэг.

Дээрх гэмт үйлдлээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, таслан зогсооход харуул хамгаалалт, аюулгүй байдлын үйл ажиллагааг хүний хүч, техник хэрэгслийг хослуулан зохион байгуулах нь үр дүнтэй байдаг.

Өнөөдөр Монгол Улсын хорих байгууллагын харуул хамгаалалтын үйл ажиллагааг гадна болон дотоодын хамгаалалт гэж ерөнхийд нь ангилан зохион байгуулж байна.

2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж эхэлсэн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, түүнд нийцүүлэн баталсан "Хорих ангийн харуул хамгаалалтын журам"-д гадна хамгаалалтын инженерийн байгууламжийг гадна хориотой бүс, хамгаалалтын хашаа, дулаан, хөдөлгөөн мэдрэх дохиолол, цахилгаан хүчдэлийн шугам, дүрс бичлэгийн хяналт бүхий зурвас, нэвтрэх хэсгийн дуу-дүрсний бичлэгийн хяналт бүхий бүстэй байхаар тогтоож, гадна хориотой бүсийг хот суурин газарт хамгаалалтын хашаанаас гадагш 500 метр, орон нутагт 1000 метр зайд байхаар хуульчилсан.

Хорих ангиудын өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавих, болзошгүй эрсдлийн үед шуурхай удирдлагаар хангах зорилгоор Шуурхай удирдлага, хяналтын төвийг байгуулан хорих анги, байгууллагуудыг дүрсний бичлэг, дохиоллын нэгдсэн системд холбосон нь харуул хамгаалалтын удирдлага, зохион байгуулалтыг сайжруулахад чухал ач холбогдолтой болсон.

Өнөөдрийн байдлаар хоригдлын зүгээс үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн тоог судлан үзэхэд 2003 он буюу 15 жилийн өмнөх үеэс 20 дахин буурсан үзүүлэлтэй байна.

Энэ нь харуул хамгаалалтын үйл ажиллагаанд дэвшилтэт техник, технологийг нэвтрүүлж, ашиглалтыг сайжруулсантай холбоотой юм.

Харуул хамгаалалтын биечилсэн хяналт, хамгаалалтын ажилтны өдөр тутмын үйл ажиллагаа болон хамгаалалтад ашиглаж буй техник хэрэгсэлд тавих шалгуур үзүүлэлтийг нэгдсэн стандартад оруулснаар зохих үр дүнгээ өгч байгаа хэдий ч тодорхой хүндрэл бэрхшээл тулгарсаар байна.

Үүнээс зарим сорилт бэрхшээлийг тодорхойлбол, Монгол Улс нь 1.6 сая хавтгай дөрвөлжин километр буюу өргөн уудам газар нутагтай бөгөөд өнөөдрийн байдлаар улс орны технологийн хөгжлөөс шалтгаалан үүрэн холбоо, интернетийн хүрэлцээ, хурд тэр бүр хангалттай хэмжээнд хүрээгүй нь улс орны тодорхой газар нутагт байршиж буй хорих ангиудын харуул хамгаалалтын технологийн хөгжилд шууд нөлөөлж байна.

Түүнчлэн байгаль, цаг уурын эрс тэс уур амьсгал бүхий өвөрмөц нөхцөлд байдгаас харуул хамгаалалтад ашиглаж буй техник нь дулааны улиралд целсийн +30, хүйтний улиралд -40 хэмд ажиллах шаардлага тулгардаг нь техникийн ашиглалтад сөргөөр нөлөөлж, эвдрэл, гэмтэл дагуулдаг.

Мөн улсын хэмжээнд 2006 оныг 2018 онтой харьцуулахад мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодистой холбоотой гэмт хэрэг 32 дахин, холбогдсон этгээдүүд 12 дахин өссөн ба дээрх төрлийн бодисыг хорих ангийн байршилд нэвтрүүлэх санаа зорилго бүхий оролдлого гарч эхэлсэн тул мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг таньж, илрүүлэх төхөөрөмжийг харуул хамгаалалтад нэвтрүүлэх зайлшгүй шаардлага урган гарч байгаа юм.

Бид өнөөдрийн байдлаар гадаадын зарим орны хорих байгууллагуудад хүндрэл учруулж буй хөдөлгөөнт утас хорих ангид нэвтрүүлэх, ашиглах зөрчилтэй тэмцэх зорилгоор сүлжээ унагаагч төхөөрөмжийг нийт хорих ангиудад нэвтрүүлэн хорих ангид хөдөлгөөнт утас хэрэглэх зөрчлийг таслан зогсоосон.

Энэ зөрчлийг таслан зогсооход хоригдлын эрх зүйн байдлыг дээшлүүлж, хоригдлын хувийн онцлог, засрал хүмүүжлийг нь харгалзан утсан харилцаагаар харилцах эрхийг нэмэгдүүлэх, зарим тохиолдолд урамшуулал хэлбэрээр олгодог болсон нь техник, технологийг эрх зүйн зохицуулалттай уялдуулан цогц байдлаар шийдвэрлэх арга замыг эрэлхийлсэнтэй холбон үзэж болно.

Гэвч дэлхий нийтэд өрнөж буй техник технологийн хурдацтай хөгжилд нийцүүлэн хорих ангийн харуул хамгаалалтад ашиглаж буй техник хэрэгслийг тухай бүр шинэчлэн сайжруулахад хүндрэлтэй байна.

Хорих ангийн харуул хамгаалалтын техникийг хариуцсан мэргэшсэн ажилтныг бэлтгэх тогтолцоог хөгжүүлэх, мэргэшсэн хүний нөөцийг бүрдүүлэх шаардлага ч урган гарч байна.

Харуул хамгаалалтын үйл ажиллагаанд техник технологийг ашиглах нь зайлшгүй боловч алба хаагчийн биечилсэн хамгаалалтын чанар, үр дүнг орхигдуулж болохгүй юм.

Харуул хамгаалалт нь "Биечилсэн хяналтад дэмжлэг үзүүлэх хэрэгсэл нь техник юм" гэсэн үндсэн агуулгын хүрээнд зохион байгуулагдах ба алба хаагчийн үйл ажиллагааг хөнгөвчлөх, туслалцаа үзүүлэхэд чиглэгдсэн байдлаар хийгдэх учиртай.

Монгол Улсын хорих байгууллагын харуул хамгаалалтын техник технологийн ашиглалт, тасралтгүй хөгжиж буй технологийн дэвшилтэй нийцүүлэхэд дараах асуудалд анхаарал хандуулан ажиллаж байна. Үүнд:

1.Хорих байгууллагын чиглэлээр мэргэшсэн техникийн ажилтнуудыг бэлтгэх, Монгол орны эрс тэс уур амьсгалд тохирсон техникийн шийдлийг бий болгоход чиглэсэн инновацийн бүтээгдэхүүнийг бий болгоход анхаарч, өөрийн улс орны техникийн сургалт, судалгааны байгууллагуудтай нягт хамтран ажиллах;

2.Хоригдогсдын бүртгэл, хяналтын нэгдсэн системийн үйл ажиллагааг байнга шинэчилэн, хөгжүүлэх;

3.Харуул хамгаалалтад ашиглаж буй техник хэрэгслийг хүний бие организмд хор нөлөөгүй, аюулгүй байдлын наад захын шаардлага хангасан байдлаар шийдвэрлэх зэрэг нь хорих байгууллагад үйлдэгдэж болзошгүй гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

ХОРИХ ЯЛААС ХУГАЦААНААС ӨМНӨ СУЛЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ /ГАДААДЫН ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА/



Б. ГАЛБАДРАХ
Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн
Харуул хамгаалалт, гүйцэтгэх ажлын тэнхимийн дэд
профессор, доктор /Ph.D/, ахмад

Товч агуулга: Илтгэлд гадаадын зарим орны хорих ялаас хугацаанаас өмнө суллах зохицуулалтын онцлогийг авч үзсэн.

Abstract: The article is devoted to the analysis of features of foreign countries in the application of early conditional release of imprisonment.

Түлхүүр үг: Хорих ял, гадаадын зарим орны эрүүгийн хууль тогтоомж, туршилтын хугацаа, хорих ялаас хугацаанаас өмнө сууллах.

Keywords: imprisonment, criminal legislation of foreign countries, early conditional release of imprisonment.

Жил бүр хорих байгууллагаас хууль заасан тодорхой үндэслэлээр 200 гаруй хүн суллагдаж байна. Эдгээрийн дийлэнх хувийг хугацаанаас өмнө суллах үндэслэлээр суллагдах явдал эзэлж байна. Хугацаанаас өмнө суллах нь "хорих байгууллагын оршин суугчид" гэж нэрлэж болох хүний тоог бууруулах, тэдний , нийгэмшүүлэх, хүмүүжүүлэх, цаашид нийгэмд дасан зохицоход чухал ач холбогдолтой юм.

Хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллах институтийг дэлхийн дийлэнх орнууд эрүүгийн хуульдаа хуульчилсан байдаг бөгөөд нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн эрх зүйн институтийн нэг юм. Хорих ялаас хугацааны өмнө суллах институтийг анх 1855 онд Францын эрүүгийн хуульд хуульчилсан байдаг байна.

Хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллах институт нь энэрэнгүй ёсны зарчимд үндэслэсэн байдаг бөгөөд хугацаанаас өмнө ялын зорилго хангагдсан тохиолдолд ялыг цаашид эдлүүлэх шаардлагагүй гэсэн учиртай юм. Үүнээс гадна хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллах явдал нь хорих байгууллагад дэг журам сахиулах болон хоригдлыг засарч хүмүүжихэд чухал үүрэг гүйцэтгэдэг юм.

Нэгдсэн Үндэстний байгууллагаас баталсан олон улсын стандартууд хоригдлыг суллах явдалд ихээхэн анхаарал хандуулдаг. Тухайлбал НҮБ-ын Хоригдолтой харьцах наад захын жишиг дүрмийн /1955/ шинэчилсэн хувилбар болох Хоригдлуудтай харьцах наад захын жишиг дүрэм /Манделлын дүрэм 2015/-д "...хоригдлыг суллахын өмнө түүнийг тодорхой шат дараалалтайгаар нийгэмд эргэн нэгтгэх арга хэмжээг хэрэгжүүлэх" гэж заасан байдаг. Энэ зорилгын хүрээнд хоригдол бүрийн хувь хүний онцлогийг харгалзан үзэх, суллагдсан болон суллагдах дөхсөн хоригдлуудад тусгай дэглэм, нөхцөлийг тогтоох, суллагдсаны дараа хяналтад байх туршилтын хугацааг тогтоох бөгөөд хяналтыг цагдаагийн байгууллага тавихгүй бөгөөд нийгмийн халамжийн үйлчилгээ, туслалцаа үзүүлэх хэрэгтэй гэж онцлон заасан байна[1]. Манделлын дүрэмд заасан тус хэм хэмжээний гол агуулга нь пробацийн албаны хяналт бөгөөд үүний хүрээнд хорих байгууллагаас суллагдсан, нийгэмд эргэн нэгдэх оролдлого хийгдэж буй этгээдэд нийгмийн халамжийн үйлчилгээ, сэтгэл зүйн болон бусад туслалцааг үзүүлэх юм.

Хорих ялаас хугацаанаас өмнө суллах институтийг хэрэглэхэд хоёр үндэслэл байх нь чухал юм:

1. Материаллаг (ялын зорилго хангагдсан).
2. Ялын тодорхой хугацааг эдэлсэн.

Дийлэнх гадаадын орнуудын хууль тогтоомж нь XIX-XX зуунд үүссэн эрүүгийн "школ" гэж нэрлэгдэх үзэл бодлын нөлөөнд хөгжиж, хувьсан өөрчлөгдсөн байдаг. Үүний үр дүнд засан хүмүүжүүлэх байгууллага, насанд хүрээгүй хоригдлуудыг ял эдлүүлэх тусгай байгууллагууд байгуулагдаж, эрүүдэн шүүх хэлбэрийн ялын төрлөөс татгалзаж, зарим орнуудад цаазын ялаас бүрэн татгалзан, эрүүгийн хуулиасаа хасч, хорих ялаас хугацаанаас өмнө суллах явдлыг түлхүү хэрэглэж эхэлсэн байна. Энэ явдал нь ч шүүх илүү энэрэнгүй ялын төрлийг сонгож оногдуулах боломжийг ч олгосон. Энэхүү энэрэнгүй байдал нь ял эдлэхээс хугацааны өмнө суллахаар илэрдэг байна.

Гадаадын орнуудад хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллах нийтлэг хэлбэр нь хяналт дор байлгаж, хяналт тогтоож суллах юм. Энэхүү системийн гол мөн чанар нь хоригдлыг ялаас хугацааны өмнө суллаж тэдний эрх чөлөөтэй байх хугацаанд хяналт тогтоох явдал юм. Баруун болон Зүүн Европын дийлэнх орнуудад хоригдлуудад ялынхаа тодорхой

[1] Манделлын дүрэм. 87-р зүйл.

хугацааг эдэлсний дараагаар хяналт тогтоож суллагдах хүсэлт гаргахыг зөвшөөрдөг байна[2].

Эдгээр улсуудын нийтлэг тал нь хугацааны өмнө суллагдсан этгээдүүдэд хяналт тавих болон бүх шатанд хяналт тавьж байгаа алба хаагчдад өндөр шаардлага тавих механизмтай явдал юм. Бүх шат гэдэгт хугацааны өмнө суллах асуудлыг хэлэлцэх, хяналт болон суллагдсаны дараа үзүүлэх тусламжийг ойлгож болно.

Канад болон Их Британид богино хугацааны хорих ял эдэлж байгаа хоригдлуудад хугацааны өмнө суллах, хяналт тавих арга хэмжээг хэрэглэдэггүй бөгөөд үүний оронд ялынхаа тодорхой хугацааг эдэлсний дараа шууд сулладаг байна. Удаан хугацааны ял оногдуулсан тохиолдолд тухайн хоригдол хугацааны өмнө суллах бүх шат дараалаар явдаг. Их Британид зөвхөн дөрвөн жил буюу түүнээс дээш хугацаагаар хорих ял оногдуулсан этгээдийг ял эдлэхээс хугацааны өмнө суллах зохицуулалттай байдаг байна. Үүнээс гадна бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдол ялын 9-12 жилийг биеэр эдэлсэн тохиолдолд хугацааны өмнө суллагдаж болдог байна[3]. Хяналтыг биеэр эдлээгүй, ялын үлдсэн хугацаанд пробацийн албаны алба хаагч тавих зохицуулалттай.

Их Британийн чухал онцлогоос дурдвал 1997 оны "Гэмт хэрэгт оногдуулах ялын тухай хууль" нь ял эдлэхээс хугацааны өмнө суллах институтэд зарчмын гэж нэрлэж болохоор өөрчлөлт оруулсан байдаг. Тухайлбал, тус хуулийн 10 дугаар зүйлд дотоод хэргийн яамны сайд хоригдлыг гэр бүлийн тодорхой байдлаас хамааран суллах нөхцөл байдал үүссэн гэж үзсэн тохиолдолд хэзээ ч хамаагүй суллах эрхтэй гэж хуульчилсан байна.

Үүнээс гадна тус хуулийн дагуу дотоод хэргийн яамны сайдын зөвшөөрлөөр бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлуудыг ч хугацаанаас өмнө суллах боломжтой. Гэхдээ энэ зохицуулалт нь зөвхөн 18 хүртэлх насны хоригдол, тэдний үйлдсэн гэмт хэрэгт оногдуулах хорих ялын хугацааг хуульд тодорхой заагаагүй, шүүхийн тогтоолд тодорхой ялынхаа хугацааг эдэлсний дараа суллагдах боломжтой гэж заасан тохиолдолд л хамаатай гэдгийг онцлох зөв юм. Эдгээр этгээдүүдэд мөн гэр бүлийн онцгой нөхцөл үүссэн тохиолдолд хугацааны өмнө суллах

[2] Плюскин А.М. Организационно-правовые вопросы условно-досрочного освобождения осужденных к лишению свободы: дис ...канд. юрид. наук. – М., 2005, 52 дахь тал.

[3] Полянский Н.Н. Уголовное право и уголовный суд Англии. М., 1969. 102 дахь тал.

зохицуулалтыг ч хэрэглэж болдог. Энэ нөхцөлөөр суллагдсан тохиолдолд заавал биелүүлэх тодорхой нөхцөлүүдтэй байдаг. Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг сулласан шийдвэрийг дотоод хэргийн яамны сайд цуцлах, хүчингүй болгох эрхтэй байдаг бөгөөд тухайн хоригдлыг ялын үлдсэн хугацааг эдлүүлэхээр хорих байгууллагаруу буцаадаг байна.

Их Британид ял эдлэхээс хугацааны өмнө суллах ажиллагаанд "Хугацааны өмнө суллах чиг үүрэг бүхий зөвлөл" гол үүргийг гүйцэтгэдэг. 1991 оны Эрүүгийн хуулийн дагуу энэхүү зөвлөлийн бүрэлдэхүүнд зөвлөлийн тэргүүн буюу шүүгч мөн 3 гишүүн багтдаг. Хэлэлцэж байгаа хэргийн онцлогоос хамаарч Зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт орж болдог ба дотоод хэргийн яамны сайдтай зөвшилцдөг байна.

Терроризм, хүн алах, цагдаагийн ажилтан, хорих байгууллагын ажилтны амь, биед хүнд гэмтэл учруулах, насанд хүрээгүй хүнийг хүчирхийлэхийг завдах, хүчиндэх, өмнөх ялаас хугацааны өмнө суллагдан хяналтад байх хугацаандаа санаандгүй хүн алах гэмт хэрэг үйлдэж бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг ялаас хугацааны өмнө суллах асуудлыг хэлэлцэх тохиолдолд Зөвлөлийг Эзэн хааны шүүхийн шүүгч даргалдаг зохицуулалттай.

Бусад бүх тохиолдолд Зөвлөлийг орон нутгийн эрүүгийн хэргийн шүүхийн шүүгч даргалдаг. Дүрмийн дагуу тус Зөвлөлийн нэг гишүүнээр сэтгэл зүйчийг томилдог ба зарим тохиолдолд сэтгэл зүйл эсхүл пробацийн албаны офицерыг ажиллуулдаг байна. Зөвлөлийн өөр нэг гишүүнээр криминологич, сэтгэл зүйч эсхүл пробацийн албаны офицерыг ажиллуулдаг.

Франц Улсад хорих ял шийтгүүлсэн этгээд засрал хүмүүжлээ харуулсан, учруулсан хохирлоо барагдуулсан, эргэн нийгэмд нэгтгэх хангалттай үндэслэл байгаа тохиолдолд хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллах зохицуулалттай. Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлуудын хувьд 15 жилийн хорих ялыг биеэр эдэлсний дараагаар хугацааны өмнө суллах асуудлыг хэлэлцдэг байна (Франц Улсын Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 729-р зүйл)[4].

Франц Улсад хугацааны өмнө суллах эрх бүхий хүн нь хууль зүйн сайд байдаг бөгөөд хоригдлыг хугацааны өмнө суллах тогтоолыг түүнд хүргүүлж шийдвэрийг гаргуулдаг байна. Тогтоолд хоригдлын ял эдэлж

[4] Плюскин А.М. Организационно-правовые вопросы условно-досрочного освобождения осужденных к лишению свободы: дис ...канд. юрид. наук. – М., 2005, 55 дахь тал.

байгаа хорих байгууллагын дарга, ял эдлүүлэх ажиллагаа хариуцсан шүүгч, прокурор, хоригдол суллагдсаны дараа оршин суух засаг захиргааны нэгжийн тэргүүлэгч, хорих байгууллага байршиж байгаа захиргааны нэгжийн тэргүүлэгчийн саналыг тусгадаг байна (Франц Улсын Эрүүгийн байцаан шийтгэх тухай хуулийн 730-р зүйл).

Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдол хугацааны өмнө суллагдсан тохиолдолд 5-аас 10 жил хүртэл хяналт тогтоодог онцлогтой.

Америкийн Нэгдсэн Улсад хугацааны өмнө суллах асуудлыг Мужийн хугацааны өмнө суллах ажиллагаа хариуцсан зөвлөл шийдвэрлэдэг. Үйлдсэн гэмт хэргийн хөнгөн, хүндээс хамаарч хорих ялын 6/7, 2/3 эсхүл 1/2 эдэлсний дараа ялаас хугацааны өмнө суллагдах боломж үүсдэг. Нью-Йорк мужийн эрүүгийн хуулийн дагуу I зэргийн хүнд, хүн алах гэмт хэрэг үйлдсэн хоригдлыг хугацаанаас өмнө суллахыг хориглодог байна[5].

Бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлууд ч хугацааны өмнө суллагдах эрхтэй байдаг бөгөөд үйлдсэн гэмт хэрэгт оногдуулж болох ялын хугацааг эдэлсний дараа суллагдах боломжтой юм.

Үүнээс гадна АНУ-д бүх насаар хорих ялыг суллагдах боломжгүйгээр оногдуулж болдгийг дурдах нь зүйтэй. Мөн бүх насаар хорих ял шийтгүүлсэн этгээд ялын хугацааныхаа 10 жилийг эдэлсэн тохиолдолд хугацааны өмнө суллаж болдог [6]. Үүнээс гадна хорих ял эдлэхээс хугацаанаас өмнө суллахад хоригдлын цаашид биеэ авч явах чиг хандлагад ач холбогдол өгдөг. АНУ-ын Эрүүгийн хуулийн дагуу хугацаанаас өмнө суллагдаж байгаа хоригдол суллагдахын өмнө хорих байгууллагаас суллагдсаны дараа оршин суух газар, эрхлэх ажлын талаар тодорхой мэдээллийг тусгасан төлөвлөгөөг бэлдэх ёстой.

Австри Улсад бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг ялынхаа 15 жилийг биеэр эдэлсэн тохиолдолд суллаж болдог.

Австри Улсын Эрүүгийн хуульд зааснаар хугацааны өмнө суллагдсан хоригдлын биеэр эдлээгүй хугацаанаас хамаарч суллагдсан этгээдэд 1-ээс 5 жил хугацаанд туршилтын хугацааг тогтоодог. Бүх насаар хорих ял шийтгүүлсэн этгээд болон сэтгэцийн эмгэгтэй хоригдол, рецидив гэмт хэрэг үйлдсэн хоригдол хугацааны өмнө суллагдсан тохиолдолд 10 жилийн хугацаатай туршилтын хугацааг тогтоодог байна.

---

[5] Уголовный кодекс штата Нью-Йорк // Уголовное законодательство зарубежных стран: сборник законодательных материалов / под ред. И.Д. Козочкина. М., 1999. 53 дахь тал.

[6] Преступление и наказание в Англии, США, Франции, ФРГ, Японии. М., 1991. 243 дахь тал.

Хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллахыг дараах тохиолдолд хэрэглэж болохгүйг дурдах зөв юм:

- Хоригдол эрх чөлөөтэй болсны дараа гэмт хэрэг үйлдэх боломжтой гэх үндэслэл байгаа тохиолдолд;

- Бусад этгээд гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгоор ялын үлдсэн хугацааг биеэр эдлүүлэх шаардлагатай тохиолдолд.

Австри Улсад ял эдлэхээс хугацааны өмнө суллах шийдвэрийг шүүгч гаргадаг бөгөөд шүүгч хоригдолд хуулийг дагаж мөрдөх, ертөнцийг эерэгээр харахад туслалцаа үзүүлэх туслахыг томилдог байна. Туслах нь төрийн бус байгууллагын ажилтан эсхүл албан ёсны зөвшөөрөлтэй шашны байгууллагын ажилтан байж болдог.

Дани, Норвеги, Швед улсуудад ч мөн хяналтыг суллагдсан этгээдийн оршин сууж байгаа газрын орон нутгийн нийгмийн ажил эрхэлсэн сайн дурын ажилтан тавьдаг байна. Эдгээр улсуудад мэргэжлийн пробацийн алба үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд энэ байгууллага нь суллагдсан хоригдолд хяналт тавих, нийгэмд дасан зохицоход туслалцаа үзүүлдэг сайн дурын иргэдтэй хамтран ажилладаг.

Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Эрүүгийн хуулийн 57 дугаар зүйлд заасны дагуу хорих ялаас хугацааны өмнө суллах зохицуулалтыг тусгасан байдаг байна. Мөн бүх насаар хорих ял эдэлж байгаа хоригдлыг 15 жил ял эдэлсний дараа 5 жилийн туршилтын хугацаатай суллаж болдог байна. 1977 онд Германы Үндсэн хуулийн шүүх бүх насаар хорих ялыг тодорхой хугацаа нь туршилтын нөхцөлтэй байх, эдгээр хоригдлуудыг дахин нийгэмшүүлэх, засан хүмүүжүүлэх нь зохистой гэж үзсэн байна. Мөн 2-оос 5 жил хүртэл хугацаагаар туршилтын хугацааг тогтоодог. Тус улсын нэг онцлог бол хоригдлыг хугацаанаас өмнө суллахад тухайн хоригдлын өөрийн зөвшөөрөл шаардлагатай байдаг.

Тус Улсын эрүүгийн хуулийн дагуу шүүх суллагдсан хоригдлын туршилтын хугацаанд тусгайлсан туслахыг томилдог байна. Туслахын гол чиг үүрэг нь суллагдсан этгээдийн туршилтын хугацаанд түүнд халамжийн үйлчилгээ үзүүлэх, зан байдал, биеэ авч явах байдалд хяналт тавих бөгөөд мөн шүүхээс түүнд оногдуулсан үүргийг биелүүлж байгаа эсэхэд хяналт тавьдаг.

Эдийн засаг, хууль эрх зүйн салбарын хувьд хурдацтай хөгжиж буй Бүгд Найрамдах Хятад Ард Улсыг дурдахгүй өнгөрч болохгүй юм. БНХАУ-ын Эрүүгийн хууль 81-р зүйлийн дагуу хорих ял эдэлж байгаа

хоригдол ялынхаа 1/2 эдэлснээр хугацааны өмнө суллагдах боломжтой болдог бөгөөд энэ зохицуулалт нь зөвхөн 10 хүртэл жилийн ял шийтгүүлсэн хоригдлуудад хамааралтай юм. Харин давтан гэмт хэрэг үйлдсэн, 10-аас дээш жил болон бүх насаар хорих ял шийтгүүлсэн этгээдүүдийг хугацааны өмнө суллаж болохгүй гэсэн зохицуулалттай байдаг байна[7]. Хугацааны өмнө суллах саналыг Ардын дээд шүүх хянан үзэж хорих байгууллагын захиргаанд тогтоолыг хүргүүлдэг.

Мөн тус Улсын нэг онцлог бол санал ирснийг Ардын шүүх тав хоногийн дотор нийтэд мэдээлэх үүрэгтэй явдал юм. Ардын шүүх нь гэмт хэрэгтний үндсэн мэдээлэл, үйлдсэн гэмт хэрэг болон оногдуулсан ял, урьд өмнө нь үйлдэж байсан гэмт хэрэг, ял эдлүүлэх байгууллагын санал, хугацааны өмнө суллах үндэслэлийг мэдээллэдэг. Мэдээлэл нь тав хоногийн дотор хугацаатай олон нийтийн саналыг авах, холбоо барих боломжийг зааж нийтлэгддэг. Шаардлагатай тохиолдолд Ардын шүүх нь хоригдлын гэмшсэн, байгуулсан гавьяаг нотлох эсхүл ялыг хөнгөрүүлэхийн эсрэг байр суурьтай байгаа гэрч, шинжээч, орчуулагч болон бусад этгээдийг дуудаж тайлбар авдаг байна[8].

ОХУ-ын Эрүүгийн хуульд заасны дагуу ялтан өөрийн засрал, хүмүүжлээ харуулсан, учруулсан хохирлоо бүрэн эсхүл хэсэгчлэн барагдуулсан тохиолдолд хорих ялаас хугацаанаас суллаж болдог. Тухайбал, хөнгөн, хүндэвтэр гэмт хэрэг үйлдсэж ялын 1/3 эдэлсэн, хүнд гэмт хэрэг үйлдсэн бол ялын 1/2, онц хүнд гэмт хэрэг үйлдсэн бол 2/3, насанд хүрээгүй хүний бэлгийн эрх чөлөө, халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэг, мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар ашиглах, борлуулах гэмт хэрэг үйлдсэн бол 3/4 эдэлсэн тохиолдолд ялаас хугацаанаас өмнө суллаж хяналт тогтоодог байна.

Мөн хугацаагүй хорих ял буюу бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлыг 25 жил ял эдэлсний дараагаар хугацаанаас өмнө суллах асуудлыг хэлэлцэж болдог бна.

Үүнээс гадна ОХУ-ын Эрүүгийн хуулийн 56 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу терроризм, хүн барьцаалах зэрэг гэмт хэрэг үйлдсэн тохиолдолд 30 хүртэл жилийн хорих ял, эдгээр гэмт хэргийг үйлдэж хэд хэдэн шийтгэх тогтоолоор ял оногдуулсан тохиолдолд 35 хүртэл жилийн

---

[7] БНХАУ-ын Эрүүгийн хууль http:cnlegal.ru/criminal_law/china_supreme_court_parole_procedure

[8] БНХАУ-ын Эрүүгийн хууль http:cnlegal.ru/criminal_law/china_supreme_court_parole_procedure

хорих ял оногдуулдаг байна. Энэ тохиолдолд хорих ялын 3/4 хугацааг эдэлсэний дараагаар хугацаанаас өмнө суллах асуудлыг хэлэлцэж болдог байна. Гэтэл ОХУ-д бүх насаар хорих ял шийтгүүлсэн хоригдлуудын дунд 25 жил ял эдэлсэн хоригдлууд байгаа бөгөөд эдгээр хоригдлууд хэд хэдэн шийтгэх тогтоолоор яллагдсан хоригдлуудаас өмнө, тэр дундаа хугацаатай хорих ял эдэлж байгаа хоригдлуудаас өмнө суллагдах боломжтой байгаа нь эрх зүйн коллиз буюу зөрчилдөөнийг үүсгэж байна[9]. Иймд энэхүү зөрчилдөөн нь цаашид шийдвэрлэх чухал асуудлын нэг юм.

Объектив талаас хоригдлыг засарч хүмүүжсэнийг үнэлэхэд хэцүү байдаг учир зарим орны эрүүгийн хууль тогтоомжид хорих ял эдлэхээс хугацааны өмнө суллахад ял эдлэх хугацаанд биеэ зөв авч явсан зөрчил гаргаагүй байдалд анхаарал хандуулдаг. Жишээ нь Беларусь Улсад хоригдол ял эдлэх хугацаандаа зөрчил гаргаагүй, сахилга баттай байсан тохиолдолд хугацаанаас өмнө суллаж болно гэж заасан байдаг[10]. Энэхүү заалтаас хорих ял эдлэхээс хугацаанаас өмнө суллах нь урамшууллын нэг хэлбэр гэдэг нь тодорхой харагдаж байна.

Гадаадын зарим орнуудын ял эдлэхээс хугацааны өмнө суллах зохицуулалтыг судлан үзэхэд дараах дүгнэлтэд хүрч байна:

1. Ял эдлэхээс хугацааны өмнө суллах ажиллагаанд хангалттай тооны субъектүүд оролцдог бөгөөд суллах шийдвэрийг өөр өөр байгууллагууд гаргадаг. Жишээ нь АНУ, Их Британи болон Канад улсуудад ял эдлэхээс хугацааны өмнө суллах комисс, Франц Улсад хууль зүйн сайдын дэргэдэх зөвлөх хороо, Холбооны Бүгд Найрамдах Герман болон Австри улсуудад шүүх шийдвэр гаргадаг байна.
2. Биеэр ял эдлэх хугацаа харилцан адилгүй байдаг.
3. Суллагдсаны дараа туршилтын хугацаа байдаг бөгөөд мэргэжлийн пробацийн алба болон сайн дурын ажилтнууд хяналт тавьж нийгмийн халамжийн үйлчилгээг үзүүлдэг байна.

[9] Батболд Галбадрах Обеспечение прав осужденных, отбывающих наказание в виде лишения свободы, в Российской Федерации и Монголии: дис ...канд. юрид. наук. – Омск, 2018, 148 дахь тал.

[10] Уголовный кодекс Республики Беларусь // Законодательство Республики Беларусь. М., 2006. 5 дахь тал.

ХОРИХ ЯЛ ШИЙТГҮҮЛСЭН ӨСВӨР НАСНЫ ХҮНИЙГ НИЙГЭМШҮҮЛЖ БУЙ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ



Г.БАТТУЛГА
Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн эрхлэгч, дэд хурандаа



Г.БАТЖАРГАЛ
Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн багш, ахмад

Хураангуй: Энэхүү илтгэлээр хорих ял эдлүүлэх ажиллагааны нэг бие даасан онцлог чиглэл болох хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хүнийг нийгмээс тусгаарлан, ял эдлүүлэх ажиллагааг зохион байгуулж буй өнөөгийн байдал, цаашдын чиг хандлагын талаар судалгаанд суурилсан санал дэвшүүлэхийг зорих юм.

Abstract: This presentation aims to provide recommendations that are based on studies about the current situation and the future of the imprisonment of juveniles, particularly the separation from society, one of the unique features of the imprisonment system.

Түлхүүр үгс: Хорих ял, хорих ял шийтгүүлсэн өсвөр насны хүн, нийгэмшүүлэх ажил, Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага, нийгмийн ажлын үйлчилгээ

Keywords: imprisonment, juvenile delinquent, rehabilitation work, Special organization for training and character building, services of social work.

Үндсэн хэсэг

Монгол Улсын эрүүгийн хуулийн 8 дугаар бүлэгт өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын талаар тусгасан байдаг. Өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын үндэслэл, онцлогийг уг бүлэгт дараах байдлаар хуульчилжээ.

Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлгийн 8.1.4 дэх хэсэгт "Өсвөр насны хүнд хүлээлгэх эрүүгийн хариуцлага нь түүний нас, биед тохирсон, эрүүл мэнд, ёс суртахуун, сэтгэцийн онцлогийг харгалзсан, нийгэмд өөрийн байр суурийг олоход туслах, боловсрол эзэмшүүлэх, үйлдсэн гэмт хэргийнх нь хор уршгийг ухамсарлуулах, гэмт хэрэг үйлдэхэд хүргэсэн орчин, хүмүүсийн нөлөөнөөс тусгаарлах, шаардлагатай тохиолдолд гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнийг хорьж хүмүүжүүлэхэд чиглэнэ"[1] гэжээ.

Гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд зорчих эрхийг хязгаарлах, нийтэд тустай ажил хийлгэх, сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хорих ял оногдуулахаар заасан.

Монгол Улс Хүүхдийн эрхийн тухай 1989 оны НҮБ-ын конвенцод 1990 онд нэгдэн орж, түүнийг өөрийн оронд хэрэгжүүлэх зорилгоор дотоодын хууль тогтоомжийг түүнд нийцүүлэн боловсронгуй болгоход анхаарсаар ирсэн. Нөгөө талаасаа Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу Монгол улсын нэгдэн орсон конвенци дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.

Энэхүү конвенцийн 40 дүгээр зүйлд "Оролцогч улсууд эрүүгийн хууль зөрчсөн гэм буруутай нь тогтоогдсон хүүхдийн нэр төр, үнэ цэнэ, эрхийг хангаж, бусдын үндсэн эрх чөлөөг хүндэтгэх үзлийг төлөвшүүлэх, нийгмийн амьдралд буцаан оруулах, нийгэмшүүлэх ажлыг тэдний насны онцлогийг харгалзан явуулна" хэмээн заасан бөгөөд конвецод нэгдэн орсон улсын хувьд түүнийг сахиж, биелүүлэх үүргийг олон улсын хамтын нийгэмлэгийн өмнө хүлээдэг.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай Монгол Улсын хуульд Өсвөр насны хүнд оногдуулсан хорих ялыг сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагад эдлүүлнэ гэж заасан байдаг.

Манай Улсын хувьд анх өсвөр насны хүнд оногдуулсан хорих ялыг эдлүүлдэг тусгай байгууллагыг 1948 онд тухайн үеийн Дотоод явдлын яамны сайдын тушаалаар байгуулжээ. Улсын хэмжээнд цорын ганц энэхүү байгууллага нь 1964-1993 он хүртэл алслагдсан хөдөө орон нутагт байршиж байв[2].

[1] Эрүүгийн хуулийн 8 дугаар бүлгийн 8.1.4 дэх хэсэг, Эрүүгийн хуулийн шинэчлэсэн найруулга 2015 он.

[2] 1964-1978 онд МАХН-ын Төв Хороо, СнЗ-ийн 1964 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн 228\387 дугаар тогтоолоор Сэлэнгэ аймгийн Цагаан толгойд, 1978-1993 онд СнЗ-ийн 1978 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор мөн аймгийн Дарьтад тус тус байршиж байв.

Харин өнөөдөр Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага Нийслэлийн 110 дугаар бүрэн дунд сургууль гэсэн нэршил, бүтэц, тогтолцоотойгоор үйл ажиллагаа явуулдаг. Тус байгууллагад өнөөдөр 27 хүүхэд хоригдож байна. Тэдгээр хүүхдүүдийн сурч боловсрох эрхийг хангах, засрал хүмүүжил олгох, нийгэмшихэд нь туслалцаа, дэмжлэг үзүүлэн хяналт тавин зорилгоор нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, сургуулийн багш, удирдлагууд хамтран ажилладаг.

Тус байгууллагад нийгмийн ажилтан 1, сэтгэл зүйч 1 тус тус ажиллаж байгаа бөгөөд тэд 110 дугаар сургуулийн багшлах (сургалтын менежер-1, үндсэн багш-3, цагийн багш-4, гэрээт 6 багш) бүрэлдэхүүнтэй хамтран сургалтын үйл ажиллагааг зохион байгуулж байна.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн 110-р дунд сургууль нь анх Нийслэлийн засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн 2000 оны 8 дугаар сарын 10-ны өдрийн 258 дугаар тушаалаар Хөдөлмөрийн төрөлжсөн сургалттай суурь боловсрол олгох тусгай сургууль нэртэй байгуулагдаж улмаар Нийслэлийн засаг даргын 2013 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн А/545 дугаар захирамж гарч тус сургуулийн ангиллыг өөрчилж бүрэн дунд сургууль болсон байна.

Нийслэлийн 110 дугаар бүрэн дунд сургууль нь "Байгалийн ухаан", "Математик", "Мэдээлэл зүй", "Компьютер", "Монгол хэл" зэрэг 5 танхимд цөм хөтөлбөрийн хүрээнд хичээл сургалтыг зохион байгуулж байна.

Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагаас хэрэгжүүлж буй нийгмийн ажлын үйлчилгээ

1. **Хорих ял шийтгүүлсэн** өсвөр насны хүнийг тус байгууллагад хүлээн авснаас хойш нийгэмд суллагдан гарах хүртэл буюу хоригдох хугацаанд нь тус байгууллагын зүгээс ерөнхий боловсролын төдийгүй, зан үйлд нөлөөлөх, амьдрах ухааны, хүмүүжлийн эерэг нөлөө үзүүлэх, мэргэжлийн баримжаа олгох сургалтуудад хамруулдаг.

2. Сургалт хүмүүжлийн байгууллагад шинээр ирсэн хүмүүжигч хүүхдүүдтэй ганцаарчилсан уулзалт хийж, байгууллагын дотоод журам, хүмүүжигчийн эрх үүргийг тайлбарлах, ар гэрт нь мэдэгдэх, сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын онцлогийн талаар тайлбарлан ойлгуулах, тэдний сэтгэл санааны байдлыг тодорхойлж, сэтгэл зүйн болон бусад тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн нийгмийн ажил, сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлдэг.

3. Мөн хүмүүжигч хүүхдүүдийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, тэдний онцлогийг харгалзан сургалтад хамруулах, сэтгэл зүйн сорил авах, тэдэнд сэтгэл санааны дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулдаг.

Кейс 1. Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаа "*А" 17 настай: "Тус байгууллагад ирээд 1 сар гарантай болж байна. Ирсэнээсээ хойш "Хөгжмийн сургалт", "Зургийн дугуйлан" бусад амьдрах ухааны сургалтуудад хамрагдсан. Өмнө нь Цагдан хорих 461 дүгээр хаалттай ангид байхад айдас түгшүүр ихтэй, ходоод их өвддөг байсан. Гэвч энд ирсэнээс хойш ямар нэг зүйлд санаа зовох, айх зүйлгүй, сэтгэл санаа тогтуун болсон. Тус байгууллагын алба хаагчид бидэнтэй их ойр дотно харилцдаг. Заримдаа "Миний хүү ингээрэй тэгээрэй, ийм учиртай байдаг юм" гэж хэлэхэд маш дотно сайхан санагддаг. Би цаашид үсчний сургалтад хамрагдаж мэргэжилтэй болоод суллагдаж гараад өөрийн гэсэн үсчний газартай, түүнийгээ өргөжүүлээд олон салбартай болно гэж боддог"*

4. Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага нь хүмүүжигч хүүхдүүдэд хүмүүжлийн эерэг нөлөө үзүүлэх, авьяас чадварыг нээн хөгжүүлэх, мэргэжлийн чиг баримжаа олгох, амьдрах ухаанд сургах зорилгоор Төрийн бус байгууллагуудтай хамтран ажилладаг. Тухайлбал "Кристина нобелийн хүүхдийн сан" төрийн бус байгууллагуудтай 20 гаруй жилийн хугацаанд хамтран сургалт, хөтөлбөр хэргжүүлсээр иржээ. Үүнд:

а. Их дээд сургууль, коллежид сургалцах тэтгэлэгт хөтөлбөр амжилттай хэрэгжүүлдэг. Тус байгууллагын дэмжлэгтэйгээр сүүлийн 2 жилийн хугацаанд 5 хүүхэд 50-100 хувийн төлбөрийн хөнгөлөлттэй нөхцөлөөр ШУТИС, МУБИС, ХААИС, УБИС, ИЗИС сургуулиудад өөрсдийн сонгосон мэргэжлээр суралцаж байна.

б. Үүнээс гадна хүүхдийн зан үйлд урлагаар дамжуулан эерэг нөлөө үзүүлэх, сэтгэл заслын эмчилгээ хийх зорилгоор "Гар зураг"-ийн дугуйлан хичээллэж 8-10 хүүхэд тогтмол хамрагддаг бөгөөд "Хөгжимийн сургалт"-ын хөтөлбөрөөр дамжуулан урлагийн боловсрол олгодог. Хүүхдүүд гитар, морин хуур хөгжмийг шимтэн суралцаж байна.

Мөн бусад төрийн бус байгууллагадтай хамтран дараах сургалтуудыг тогтмол зохион байгуулж байна. Үүнд:

- "Амин хүүхэд" төрийн бус байгууллагатай хамтран Англи хэлний сургалтыг Мягмар гараг бүр зохион байгуулж түүнд 10 хүмүүжигч тогтмол хамрагддаг

- "АМОС" төрийн бус байгууллагтай хамтран хүүдийн зан үйлд эерэг хандлага төлөвшүүлэх "Ирээдүйн хүсэл тэмүүлэл" сэдэвт сургалтад нийт хүмүүжигч нар хамрагдаж байна.

5. Нийгмийн ажилтан, сэтгэл зүйчид, байгууллагын зүгээс хүмүүжигч нарын үйлдсэн гэмт хэргийн гэмт хэрэг, хувийн зан байдлын онцлогийг харгалзан "Уур бухимдалаа зохицуулах" хөтөлбөрт 18, "Бэлгийн хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх нь" сэтгэл зүйн бүлгийн сургалтад 17 хүмүүжигчийг хамруулан долоо хоног бүрийн Лхагва, Баасан гарагуудад тогтмол хуваарийн дагуу зохион байгуулж амжилттай харагдсан хүүхдүүдэд "Батламж" олгодог. Энэ нь тэдний засрал хүмүүжил олж хугацаанаас өмнө суллагдах, дахин гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зэрэгт чухал ач холбогдолтой бөгөөд нийгмийн амьдралд эргэн орох, дахин алдаа гаргахгүй байхад тус дэм болдог.

Кейс 2. Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад хүмүүжиж байгаа *"Б" тус байгууллагад ирээд ерөнхий боловсролын сургуулиа төгссөн. Мөн "Нарийн боов"-ны мэргэжил эзэмшсэн. Суллагдан гараад хүмүүс миний талаар юу гэж ярих бол гэж их санаа зовдог.*

6. Нийгэмд эргэн нэгтгэх, эрх чөлөөт амьдралд бэлтгэх чиглэлээр "Уур бухимдлаа зохицуулах нь", "Харилцааны чадварт суралцах нь" болон "Асрал төв" төрийн бус байгууллагатай хамтран хүмүүжигчийн сөрөг зан байдал, харилцааны ур чадварыг сайжруулах зорилго бүхий бүлгийн сургалтыг зохион байгуулдаг.

7. Мөн суллагдах дөхсөн хүмүүжигч нарыг бичиг баримтжуулах, иргэний бүртгэлд хамруулах ажлыг орон нутгийн Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтран зохион байгуулдаг. Тухайлбал өнгөрсөн онд иргэний үнэмлэх шинээр авах 7, нөхөж авах 2 нийт 9 хүмүүжигчийн иргэний шинэчилсэн бүртгэлд хамруулжээ.

8. Хүмүүжигч нарын гэр бүлийн эерэг харилцааны хэвийн байдлыг хадгалах, гэр бүл, нийгэмтэй ойр байлгах, суллагдан гараад гэр бүлийнхээ дэмжлэгийг авч хэвийн амьдрах нөхцлийг хангах зорилгоор "Нээлттэй хаалганы өдөрлөг" зохион байгуулдаг. Тухайлбал Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагаас 2019 оны 05 дугаар сарын 30-ны өдөр зохион байгуулсан "Нээлттэй хаалганы өдөрлөг"-т хүмүүжигчдийн гэр бүл, ойр дотны хүмүүс, хамтран ажилладаг төрийн болон төрийн бус байгууллагаас иргэд хүрэлцэн ирж оролцсон.

Өдөрлөгийн үеэр хүмүүжигчид урлагийн тоглолт үзүүлж, өөрсдийн хийсэн ноос, эсгий урлалын бүтээл, талх, нарийн боов, гар зургуудаар үзэсгэлэн гаргаж арга хэмжээнд хүрэлцэн ирсэн зочид төлөөлөгчид, ар гэрийнхэндээ үзүүлсэн байна.

Кейс 3. Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын ажилтан *"Г" хүмүүжиж байгаа хүүхдүүдийн гэр бүлийг судлахад эцэг эхийн хараа хяналт сул, архи уудаг, ажилгүй, гэр бүл салсан, эсвэл харилцаа хандлагын хувьд доголдолтой байдаг тул эцэг эх, асран халамжлагч нарыг чадвархижуулах нь чухал.*

9. Гэмт хэрэг үйлдсэн хүүхдийг нийгэмшүүлэх, хүмүүжүүлэхэд хорих байгууллага эцэг, эх, гэр бүлийн хамтын ажиллагаа ихээхэн чухал бөгөөд тэдэнд чиглэсэн нөлөөллийн болон сургалтын ажлыг зохион байгуулах талаар сургалт хүмүүжлийн байгууллагын зүгээс ихээхэн анхааран ажилладаг.

10. Түүнчлэн хүүхэдтэй ажиллах ялангуяа гэмт хэрэг үйлдсэн, зан байдлын хувьд доголдолтой хүүхэдтэй ажиллахад сургалт хүмүүжлийн байгууллагын нийгмийн ажилтан, сэтгэл зүйч бусад алба хаагчдаас хүүхэдтэй харилцах арга зүй, ур чадвар ихээхэн шаардлагатай байдаг.

Цаашид энэ чиглэлээр анхааран ажиллах, тус байгууллагад ажиллах алба хаагчдыг сонгон шалгаруулах, томилон ажиллуулахдаа анхаарах, тэднийг сургаж дадлагажуулахад анхаарах хэрэгтэй юм.

Кейс 4. Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагын ажилтан *"Г" Сургалт хүмүүжлийн тусгай байгууллагад ажиллах нийт алба хаагчдыг хүүхэдтэй ажиллах арга зүйн чиглэлийн сургалтад хамруулах, тогтвор суурьшилтай ажиллуулах шаардлагатай байдаг. Жишээ нь насанд хүрэгчдийн хаалттай хорих ангид ажиллаж байгаад шууд томилогдон ирж ажиллах тохиолдол байдаг.*

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Сургалт хүмүүжлийн тусгай байгууллага нь ШШГЕГ, бусад байгууллага, иргэдтэй хамтран гэмт хэрэг үйлдсэн хүүхдүүдийг хүмүүжүүлэх, дахин гэмт хэрэг, зөрчилд холбогдохоос урьдчилан сэргийлэх, тэднийг хуулиа сахин биелүүлдэг иргэн болгон төлөвшүүлэхэд чиглэсэн сургалт, хүмүүжлийн олон талт ажлыг амжилттай хэрэгжүүлсээр ирсэн.

Гэвч өнөөдөр бидэнд анхааран авч үзэх, шийдвэрлэвэл зохих хэд хэдэн асуудал байгаа нь алба хаагчид, хүмүүжиж буй хүүхдүүдээс авсан судалгаа, тус байгууллагаас хэрэгжүүлж буй сургалт хөтөлбөрт хийсэн дүн шинжилгээ зэргээс харагдаж байна. Үүнд:

Нэг. Одоогийн байгаа сургалт хүмүүжлийн байгууллага нь өмнө насанд хүрэгчдийн хорих анги байсан бөгөөд үүнээс хамааралтай хорих ангийн орчин нөхцөл хадгалагдсаар байна. Иймд тус байгууллагын орчин нөхцлийг сайжруулах, тусгайлсан дүрэм, стандартыг боловсруулж мөрдөх шаардлагатай.

Хоёр. Насанд хүрээгүй хүмүүстэй тогтмол буюу дагнан ажилладаг, насанд хүрээгүй хүнийг гэмт явдлаас урьдчилан сэргийлэх асуудлыг голчлон эрхэлдэг албан хаагчид болон нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийг тусгайлан бэлтгэн насанд хүрээгүй хүмүүстэй харьцах талаар мэргэшүүлэх

Гурав. Өсвөр насны хүний эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан сургалт, нийгмийн ажлын үйлчилгээ үзүүлэх. Гэр бүлийн харилцаа сэргээх буюу гэр бүлийн таатай орчныг бүрдүүлэхэд анхаарах. Суллагдан гарсаны дараа нийгмийн ажлын үйлчилгээг тасралтгүй үр дүнтэй явуулах.

СЭТГЭЦИЙН ТУЛГАМДСАН АСУУДАЛТАЙ ХОРИГДОЛТОЙ АЖИЛЛАХАД АНХААРАХ АСУУДЛУУД



Б.МӨНХБААТАР
Дотоод хэргийн их сургуулийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн сургуулийн Нийгмийн ажил, сэтгэл зүйн тэнхимийн багш, ахмад



Н.БОЛОРМАА
ШШГЕГ-ын Хорих ял эдлүүлэх албаны Сургалт, нийгэм, сэтгэл зүйн хэлтсийн Сэтгэл зүйн тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн, ахмад

Товч утга: Энэхүү илтгэлээр хорих ял эдлүүлэх ажиллагаан дахь тулгамдсан асуудлуудын нэг болох сэтгэцийн тулгамдсан асуудалтай хоригдогчийн онцлог, нөхцөл байдалд хэсэгчилсэн шинжилгээг хийж, цаашид анхаарах асуудлуудын талаар санал дэвшүүлэн, туршлага солилцохыг зорилоо.

Abstract: The aim of this presentation is to segmentally analyze the conditions and characteristics of the inmates who have mental problems, that is one of the urgent issues of the operations of the imprisonment system, discuss and exchange good practices, and recommend future actions.

Түлхүүр үг: Хорих ял эдэлж байгаа хоригдлын сэтгэл зүйн тулгамдсан асуудал, сэтгэл зүйч, нийгэмшүүлэх ажил, оюуны дутуу буюу хомсдол, зан төрхийн өөрчлөлт.

Keywords: Psychological issues of inmates, psychologist, rehabilitation work, mental illness or mental deficiency, behavioral changes.

Манай орны эрх зүйн шинэтгэлийн хүрээнд Эрүүгийн болон эрүүгийн ял эдлүүлэх эрх зүйн салбарт сүүлийн үед томоохон өөрчлөлтүүд хийгдэж, эрүүгийн ялын бодлого нь хатуу чанга, нэг талыг барьж туйлшран хэлбийх бус гэмт хэрэг үйлдэж хорих ялаар шийтгүүлэгсдэд хандах хүмүүнлэг үзэл санааг дэмжих, хүний эрхийг дээдлэх, хорих ял эдлүүлэх нөхцөлийг

сайжруулах, хоригдлын жам ёсны эрхийг хангахад чиглэн ажиллаж байгаа билээ.

Монгол Улс дахь хорих ял эдлүүлэх ажиллагаа түүхэн хөгжлийнхөө явцад хүртэл хорих ял эдлэгсдийг сурган хүмүүжүүлэх талаар олон талт бодлогыг барьж, хэрэгжүүлэн ажилласаар ирсэн нь хууль, тогтоомж, судалгаа, шинжилгээний тайлан, судлаачдын илтгэлээс харагдаж байдаг.

Хоригдогсдыг хөдөлмөрт сургах, мэргэжил эзэмшүүлэх зэргээр хорих ял эдлэгсдэд зориулсан сургалт, хүмүүжлийн ажил зохион байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж ирсэн билээ.

Эрүүгийн ялын зорилгыг хангах, ял эдлүүлэх ажиллагааг хэрэгжүүлэхэд хорих байгууллагын үндсэн нэг чиг үүрэг нь хоригдолд үзүүлэх нийгмийн ажлын[1] үйлчилгээ юм.

Тэр ч утгаараа өнөөгийн байдлаар хоригдлыг нийгэмшүүлэх, тэдгээрт тулгарсан бэрхшээлийг даван туулахад туслах чиг үүрэг бүхий "Нийгмийн ажилтан", "Сэтгэл зүйч"[2] -ийн орон тоо батлагдан хорих ангиудад үйл ажиллагаагаа зохион байгуулж байна.

Хорих ангийн сэтгэл зүйч, эмч нар сэтгэцийн тулгамдсан асуудалтай хоригдолд сэтгэл зүйн үйлчилгээг хүргэж, тэдний сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр тодорхой ажлуудыг зохион байгуулан ажиллаж байгаа хэдий ч сэтгэцийн тулгамдсан асуудалтай хоригдолтой ажиллах тал дээр анхаарах асуудлууд байсаар байна.

Хорих ял эдлүүлэх явцад хоригдлын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, сэтгэцийн тулгамдсан асуудалтай хоригдолтой ажиллах асуудлыг амжилттай зохион байгуулан, хэрэгжүүлсэнээр хоригдолд чиглэсэн эмнэлэг- сэтгэл зүйн үйлчилгээний үр дүнд чухал нөлөө үзүүлнэ гэж бид харж байна. Үүнд:

- Сэтгэцийн тулгамдсан асуудалтай хоригдолтой ажиллахад анхаарах асуудлыг алба хаагч бүр таньж мэдэж, улмаар өөрийн ажил үүрэгтээ хэрэгжүүлнэ.

---

[1] 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр батлагдсан Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ын 5.1-д "Эрүүгийн хариуцлагын зорилго нь гэмт хэрэг үйлдсэн хүн, хуулийн этгээдийг цээрлүүлэх, гэмт хэргийн улмаас зөрчигдсөн эрхийг сэргээх, хохирлыг нөхөн төлүүлэх, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн хүнийг нийгэмшүүлэхэд оршино."

[2] 2013 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр батлагдсан "СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/" 3.1.19."сэтгэл зүйч" гэж их, дээд сургуулийг сэтгэл зүйн мэргэжлээр төгссөн мэргэжилтнийг;

- Сэтгэцийн тулгамдсан асуудалтай хоригдол, түүнд үзүүлэх үйлчилгээний чанар сайжирна.
- Гэмт хэрэг үйлдсэний улмаас хорих ялаар шийтгэгдсэн этгээдийн хувьд цагдан хорих газар /төв/, дамжин өнгөрүүлэх анги болон хорих ангид ирэхэд судалгаа шинжилгээний ажлыг зохион байгуулан, орчны өөрчлөлтөд дасан зохицох тал дээр анхаарч тодорхой арга хэмжээг зохион байгуулна.
- Хоригдлыг орчноос хамаарах сэтгэцийн ямар нэг өөрчлөлт, хямралд орохоос урьдчилан сэргийлэх нөхцөлийг бүрдүүлж өгнө.
- Хоригдлын сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах чиглэлээр бодитой ажил зохион байгуулагдана.

Хорих ял эдэлж байгаа сэтгэцийн тулгамдсан асуудалтай хоригдолтой ажиллаж байгаа өнөөгийн нөхцөл байдалд дүн шинжилгээ хийхэд:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харъяа анги албад, цагдан хорих байранд хоригдож байгаа хоригдогсдын сэтгэл зүйг авч үзэхэд 3 хоригдлын 1 нь эрүүл, 2 нь сэтгэцийн тулгамдсан асуудалтай гэж тодорхойлогдсон байдаг.

Сүүлийн үед сэтгэцийн эмгэг өвчинтэй хоригдлууд ч цөөнгүй хэрэгт холбогдож байна.

Хорих ялаар шийтгэгдсэн хоригдлууд нь сэтгэл зүйн талаас ямар нэг байдлаар сэтгэхүйн, сэтгэл хөдлөлийн буюу зан үйлийн түр зуурын хямралд ихээхэн өртдөг нь судалгааны үр дүнгээс харагдаж байна.

Иймд хорих ялын хугацааг гүйцэд эдлэх чадваргүй байдалд хүргэдэг Шизофрени өвчний хэлбэрүүд, Эпилепси өвчин, Эпилепсийн тэнэгрэл, даамжрах саа, өтлөлтийн өмнөх солиорол, тархины гэмтлийн шалтгаант Эпилепси, тархины органик өвчний шалтгаант мэдэгдэхүйц тэнэгрэл зэрэг сэтгэцийн өвчнийг анхааралд авах хэрэгтэй байна.

Нэгдсэн эмнэлэгт жилдээ давхардсан тоогоор 3000 орчим хоригдол хэвтэн эмчлүүлдэг. Үүнээс давхардсан тоогоор 220 гаран удаа сэтгэцийн эмгэгтэй болон сэтгэцийн өөрчлөлтөд орсон хоригдол хэвтэн эмчлүүлдэг бол үлдсэн хоригдлуудын 70-80% нь үндсэн өвчнөөс гадна сэтгэцийн тулгамдсан асуудалтай байна.

Хүн амын дунд явуулсан судалгааны материалаас үзэхэд:

Зонхилон тохиолдох сэтгэцийн эмгэг	Өвчтөний эзлэх хувь	
	Хүн амд явуулсан судалгааны материал	
	Сэтгэцийн бүх эмгэгүүдийн дунд эзлэх хувь /%/	Нийт хоригдогсдын дунд эзлэх хувь /%/
Оюуны хомсдол	48.2	7.2
Айдас түгшүүрийн	11.9	0.5
Сэтгэл гутрах эмгэг	1.0	0.15
Тайлбарлаж болмооргүй биеийн зовуурь шаналгаанууд	1.0	0.5
Сэтгэцийн бусад эмгэг	22.2	0.01
Уналт таталт, зан төрхийн өөрчлөлт	16.5	4.5

Дээрх хүснэгтээс үзэхэд нийт хоригдогсдын 7,2 хувь нь оюуны дутуу буюу хомсдолтой, 4,5 хувь нь уналт таталт, зан төрхийн өөрчлөлттэй гэж оношлогдсон байгаа нь цаашид илүү нарийвчлан судлах шаардлагыг бий болгож байна.

Өөрөөр хэлбэл оюуны дутуу буюу хомсын эмнэл зүйн шинж чанараас авч үзвэл сэтгэн бодох чадвар, хэл яриа, сэтгэхүйн үйлдлийн дутуу буюу хомсдолыг судлах шаардлага илүүтэй тулгарч байна.

Тэдний хийж байгаа үйлдэл хөдөлгөөнүүдийн ихэнх нь тухайн үед төрсөн биологийн болон дур хүслийн хэрэгцээг хангахад чиглэгддэг бөгөөд оюуны хомсдолтой хүмүүст хулгай хийх дур, дэмий тэнэх дур, архидах дур, иддэггүй юм идэх дур, хоол хэт их идэх дур, ер бусын замаар бэлгийн дур хүслээ хангах дур, хэвийн хэмжээнээс ихэссэн бэлгийн дур зэрэг илрэл бүхий бие сэтгэцийн дотоод ертөнцийг эзэмдсэн эмгэг дур хүслүүд илэрч байгааг нарийвчлан судлах шаардлагатай байна.

Хорих ял эдэлж байгаа сэтгэцийн тулгамдсан асуудалтай хоригдолтой ажиллахад тулгарч байгаа бэрхшээл нэлээдгүй байна. Үүнд:

1.Сэтгэцийн тулгамдсан асуудалтай хоригдолтой харилцахад алба хаагч, харуул хамгаалалтын ажилтны зүгээс хүндрэл бэрхшээл нэлээдгүй

тулгардаг. Тухайлбал хоригдлын зүгээс биеэ хянах чадвар алдагдах, амиа хорлох үйлдэл хийх, бие эрхтэндээ санаатайгаар гэмтэл учруулах, орчны эд зүйлийг эвдэх бусадтай маргалдах зэрэг үйлдлүүд үүсэх явдал гарч байна.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвөөс Шизофрени оноштой, хэвтэн эмчилгээ хийлгэж байсан хоригдол тухайн гэмт хэрэгт холбогдох үедээ солиорол илрээгүй тул шүүхээс хэрэг хариуцах чадвартай гэж тогтоогдсон байдаг.

Одоогоор хорих ял эдэлж байгаа бөгөөд зан төлөвийн хувьд үе үе тодорхойгүй шалтгаанаар уурлах, бухимдах, бусадтай харилцааны зөрчил гаргах магадлал өндөртэй, бусдын болон өөрийн бие махбодид гэмтэл учруулах эрсдэлт эмгэг зан төрхийн өөрчлөлт илэрч ямар нэгэн үйлдэл хийж болзошгүй байдаг тул байнгын харуул хамгаалалтын хяналтад байдаг.

Ийм төрлийн өвчлөл нь өвчтөний сэтгэл санааг хэвийн бус болгодог боловч хэрэг хариуцах чадварыг [3] алдагдуулдаггүй, мөн түүнчлэн сөргөлдөөнтэй байдалд гадны нөлөөг эсэргүүцэх чадварыг эрс бууруулдаг бөгөөд энэ нь нийгэмд хэрэгтэй зан чанар тогтож төлөвшихөд саад учруулж, өөрийгөө хянах үйл явцыг саармагжуулж, эрх зүйн зөрчил, гэмт хэрэг үйлдэх явдлыг хөнгөвчлөх нэг төрлийн хүчин зүйл болдог тул анхаарахгүй орхиж болохгүй байна.

2. Сэтгэцийн эмгэг, өвчинтэй хоригдол нь хорих байгууллагын нэгдсэн эмнэлгийн хяналтад байдаг бөгөөд эмэн эмчилгээнд тогтмол хамрагдаж, тус ангийн сэтгэл зүйч тодорхой хугацааны давтамжтайгаар уулзалт зохион байгуулан ажиллаж байгаа хэдий ч энэ талын нарийвчилсан зохицуулалт байхгүй байгаа нь энэ төрлийн сэтгэцийн өвчлөлтэй хоригдолтой ажиллах арга, аргачлал, туршлага бага байгаатай холбоотой байна.

Эмнэлгийн хяналтад байсан ч солиорлын хурц шинж тэмдэг илэрч буй хоригдолд эмэн эмчилгээ хийж засрал сайжралын байдалтай болгосны

[3] 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр батлагдсан Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ын 6.3 дугаар зүйлийн 2 дугаар хэсэгт "Сэтгэцийн эмгэг, оюун ухааны хомсдолын улмаас өөрийн үйлдлийн бодит шинж чанар, аюултай байдлыг ухамсарлах, удирдан жолоодох чадваргүй болсныг хэрэг хариуцах чадваргүйд тооцно";
Мөн хуулийн 6.3 дугаар зүйлд "Хэрэг хариуцах чадвар" заалтын 3 дугаар хэсэгт "Гэмт хэрэг үйлдэх үедээ хэрэг хариуцах чадваргүй байсан хүнд ял оногдуулахгүйгээр энэ хуульд заасан эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэнэ" гэж тус тус заасан байдаг.

дараа эмнэл зүйн чиглэлийн сэтгэл зүйн үйлчилгээгээр дэмжих явдал учир дутагдалтай байгаа юм.

3. Хорих ангид шинээр таслагдан ирсэн хоригдол нь өөрийн хийсэн хэрэгтээ гэмшин, сэтгэл санаа хямарч, гэмт хэргийн шокын байдалд орох, цагдан хорих хугацаандаа дасан зохицох эмгэг үүсэж анхаарал төвлөрөлт, тогтворжилт буурсан, өөрийн хяналт суларч, сэтгэл санаа тогтворгүй, уур бухимдал ихсэх, эмх цэгцгүй яриа өгүүлэлтэй болох зэрэг шинжүүд ажиглагдаж улмаар сэтгэцийн эмгэг өвчинтэй болох тохиолдол гардаг.

Гэмт хэрэг үйлдэж ял шийтгэгдсэний дараа *сэтгэцийн эмгэгтэй* болж өөрийн үйлдлийн бодит шинж чанар, хор уршгийг ухамсарлах, үйлдлээ удирдан жолоодох чадваргүй болсон хүнийг ял эдлэхээс чөлөөлж, эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх[4] талаар зохицуулалт хүртэл байдаг.

САНАЛ, ЗӨВЛӨМЖ

Өнөөгийн нийгэмд гэмт хэргийн гаралт, шинж чанар нь улам хэрцгий шинж чанарыг агуулж, нийгмийн хор аюул нь хурдацтай өсөж байгаа нь сэтгэцийн эмгэгийн анхдагч урьдчилан сэргийлэлтийг[5] идэвхтэй зохион байгуулах шаардлагатайг харуулж байна.

---

[4] 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр батлагдсан Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ын 6.13 дугаар зүйлийн "Хорих, зорчих эрхийг хязгаарлах ялаас өвчний учир чөлөөлөх" заалтын 1 дүгээр хэсэг

Мөн хуулийн 6.13 дугаар зүйлийн 2 дугаар хэсэгт "Шүүх гэмт хэрэг үйлдэж ял шийтгэгдсэний дараа ял эдлүүлэхэд саад болохуйц өвчнөөр өвчилсөн тохиолдолд ялтныг ял эдлэхээс чөлөөлж болох бөгөөд энэ журмыг хуулиар тогтооно"

[5] 2013 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр батлагдсан "СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/"3.1.5."сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах" гэж хүн амд үзүүлэх сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг зохион байгуулж, сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалахад чиглэсэн анагаах ухаан, нийгэм, сэтгэл зүй, эдийн засгийн цогц арга хэмжээг;

Мөн хуулийн 3.1.6."сэтгэцийн эмгэгийн анхдагч урьдчилан сэргийлэлт" гэж иргэд, хамт олны дунд сэтгэц-зан үйлийн эмгэгт нөлөөлж байгаа хүчин зүйлийг тандах, хянах, урьдчилан сэргийлэх, бууруулахад чиглэсэн эрүүл мэнд, нийгмийн цогц арга хэмжээг; 3.1.7."сэтгэцийн эмгэгийн хоёрдогч урьдчилан сэргийлэлт" гэж өрхийн болон сум, тосгоны эрүүл мэндийн төвд сэтгэц, зан үйлийн эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийн анхны тусламж үзүүлэх, лавлагаа, тусламжид илгээх, хяналт тавих арга хэмжээг; 3.1.8. "сэтгэцийн эмгэгийн гуравдагч урьдчилан сэргийлэлт" гэж аймаг, дүүргийн эрүүл мэндийн байгууллага, тусгай мэргэжлийн төвд сэтгэцийн эмгэг даамжран архагшиж, хүний хөдөлмөрийн чадварыг алдуулах, хөгжлийн бэрхшээлтэй болохоос сэргийлэх зорилгоор үзүүлэх эмнэлгийн төрөлжсөн мэргэжлийн тусламжийг;

Сэтгэцийн тулгамдсан асуудалтай хоригдолтой ажиллахад тулгарч байгаа бэрхшээл, хүндрэлд дүн шинжилгээ хийн дараах чиглэлд анхаарал хандуулан хөгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:

Нэг. Хоригдлыг орчин нөхцөлд дасан зохицох хугацаанд тохирох сэтгэл зүйн зөвлөгөөг сэтгэл зүйч нар тогтмол өгч байгаа хэдий ч үр дүнг тооцох, сэтгэцийн эмгэгтэй хүмүүстэй харилцах сэтгэл зүйчийг чадваржуулахад анхаарах;

Хоёр. Тусгайлан энэ төрлийн өвчлөлтэй хоригдолтой ажиллахад эмнэл зүйн сэтгэл зүйчээр мэргэшсэн алба хаагч[6], сэтгэл зүйн тогтолцоог бий болгох;

Гурав. Сэтгэцийн эмгэгийн анхдагч урьдчилан сэргийлэлтийг тухайн хоригдол, хоригдогсдын дунд сэтгэц-зан үйлийн эмгэгт нөлөөлж байгаа хүчин зүйлийг тандан судалж тодорхойлон хянах, урьдчилан сэргийлэх, бууруулахад чиглэсэн сэтгэл засалч эмч, сэтгэл зүйч нарын хамтран ажиллах тогтолцоог хөгжүүлэх;

Дөрөв. Сэтгэцийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулахад судалгаа, шинжилгээний ажлыг илүү эрчимжүүлэх, сэтгэцийн эрүүл мэндийн болон мэргэжлийн байгууллагын үүрэг оролцоог нэмэгдүүлэх зэрэг бодитой ажил хэрэг болгох хэрэгцээ шаардлага бий болсоор байна.

Хоригдолтой ажилладаг эмч, эмнэлгийн мэргэжилтэн, сэтгэл зүйч, нийгмийн ажилтан, харуул хамгаалалтын ажилтнуудад мэргэжлийн байгууллагаас сургалт тогтмол давтан авах, хоригдлын сэтгэл зүйн чиглэлээр бусад орны ижил чиг үүрэг бүхий мэргэжилтнээс харилцан туршлага судалж урт богино хугацааны сургалтад хамруулан, цаашид тэдний залгамж халааг бэлтгэж, зорилтот бүлгийн хэрэгцээг ханган ажиллах нь бидний нэн түрүүнд авч хэрэгжүүлэх ажил юм.

[6] 2013 оны 01 дүгээр сарын 03-ны өдөр батлагдсан "СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/"3.1.16."**сэтгэцийн эмч**" гэж анагаах ухааны боловсрол олгох их, дээд сургууль төгссөн, сэтгэцийн эмчийн мэргэшүүлэх сургалтын хөтөлбөрийг дүүргэж, эмчлэх эрхийн зөвшөөрөл авсан хүний их эмчийг; 3.1.17."**эмнэл зүйн сэтгэл зүйч**" гэж эмнэл зүйн сэтгэл зүйгээр төрөлжсөн мэргэшил эзэмшсэн сэтгэцийн эмчийг;

"ХОРИХ ЯЛ ЭДЛҮҮЛЭХ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ДҮН ШИНЖИЛГЭЭ" СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН



А.ЖАРГАЛЗАЯА
Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний нэгдсэн хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан, ахмад

Товч агуулга: Энэхүү илтгэл нь Монгол Улсын хэмжээнд 2003-2018 оны хооронд үйлдэгдсэн гэмт хэрэг, шүүхээс оногдуулсан хорих ял, түүнийг эдлүүлэх ажиллагаа, тухайн үед мөрдөгдөж байсан олон улсын болон үндэсний хууль тогтоомж, түүний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийсэн судалгааны тайлангаас гарсан нэгдсэн дүгнэлт юм.

Abstract: This report is a summary which was taken research reports and analyzes on the crimes and criminal acts committed during the period of 2003-2018 in Mongolia, legal penalties imposed for these crimes, execution of sentences, international and national legislations implemented during the years, as well as its implementation.

Түлхүүр үг: Гэмт хэрэг, ял шийтгэл, хорих ял, ял эдлүүлэх ажиллагаа, хорих ял эдлүүлэх дэглэм, хоригдлыг нийгэмшүүлэх ажил

Key words: Crime, punishment, sentence, imprisonment, execution of sentence, conviction, regime of imprisonment, prisoner rehiabilitation

Дотоод хэргийн их сургуулийн Эрдэм шинжилгээний хүрээлэнгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэл судлалын төвөөс санаачлан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Хорих ял эдлүүлэх албаны захиалгаар "Хорих ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилтэд хийсэн дүн шинжилгээ" судалгааны ажлыг Монгол Улсын хэмжээнд 2003-2018 оны хооронд үйлдэгдсэн гэмт хэрэг, шүүхээс оногдуулсан хорих ял, түүнийг эдлүүлэх ажиллагаа, тухайн үед мөрдөгдөж байсан олон улсын болон үндэсний хууль тогтоомж, түүний хэрэгжилтэд дүн шинжилгээ хийж судалгааны тайлан болгон нийтийн хүртээл болгосон юм.

Хорих ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилтийг эрх зүйн зохицуулалтын болон практикийн хүрээнд тулгамдаж асуудлыг тодорхойлсон судалгаа шинжилгээний бие даасан ажил хомс байхын

зэрэгцээ шинэчлэн батлагдсан Эрүүгийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн хүрээнд уг ялыг хэрэгжүүлэх онол, арга зүйн судалгаа зайлшгүй шаардлагатай байгаа энэ цаг үед өөрийн орны хорих ял эдлүүлэх ажиллагааны нөхцөл байдлыг тоймлон харах боломжийг энэхүү дүн шинжилгээний тайлан олгоно.

Судалгаанд ашигласан статистик тоо баримт, үйл ажиллагааны мэдээлэл нь Шүүхийн ерөнхий зөвлөл, Улсын Ерөнхий Прокурорын газар, Цагдаагийн Ерөнхий газар, Статистикийн төв газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар зэрэг төрийн байгууллагын албан ёсны тайлан, мэдээнд тулгуурласан хэдий ч тус тайлан нь Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын удирдлагын байр суурь болон үйл ажиллагааны чиг хандлага, хэрэгжилтийн түвшинг илэрхийлээгүй бөгөөд зөвхөн судлаачдын хөндлөнгийн судалгаа боловсруулалтын ажлын үр дүн болно.

Хоёр. Судалгааны ажлын үр дүн

Хорих ял эдлүүлэх ажиллагаа гэж хорих ялаар шийтгэгдсэн этгээдийг суллагдасны дараа дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх зан үйлийг төлөвшүүлэн нийгэмшүүлэхэд чиглэгдсэн хорих байгууллагад хуулиар эрхийн хязгаарлалт тогтоон, тодорхой дэглэм, журмын хүрээнд аюулгүй байдлыг ханган хориж буй арга хэмжээ юм.

Хорих ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилт /2003-2018/ дүн шинжилгээний тайлан гаргахтай холбоотой судалгаа-боловсруулалтын ажлыг хийсний дүнд дараах дүгнэлтэд хүрлээ.

Нэг. Монгол Улсад 2003-2018 онд үйлдэгдсэн гэмт хэрэг, түүнд оногдуулсан ял шийтгэлд хийсэн шинжилгээний хүрээнд:

1.Монгол Улсад 2003 онд-19934, 2004 онд-18905, 2005 онд-17411, 2006 онд-18253, 2007 онд-21268, 2008 онд-20704, 2009 онд-20373,2010 онд-19825, 2011 онд-19197, 2012 онд-22089, 2013 онд-25362,2014 онд-27318, 2015 онд-27757, 2016 онд-27167, 2017 онд-32259, 2018 онд-36220 гэмт хэрэг үйлдэгдсэн байна. Энэ нь 2018 онд үйлдэгдсэн нийт гэмт хэрэг нь 1968 он буюу 50 жилийн өмнөхтэй харьцуулахад 10 дахин, 2003 онтой харьцуулахад 1,8 дахин өссөн үзүүлэлтэй байна.

2. 2003-2018 оны хооронд нийт бүртгэгдсэн бүртгэгдсэн гэмт хэргийн үзүүлэлтийг харьцуулж үзвэл хүнийг санаатай алах, бусдын бие махбодод гэмтэл учруулах, хулгай, дээрэм, танхай, хүчин, хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг дийлэнхи байр суурийг буюу 2003-2016 оны

хооронд 60-75%-ийг эзэлж байсан бол 2017 оноос хойш 50 хүрэхгүй хувийг эзэлдэг болсон байна.

3. Сүүлийн 3 жилд буюу 2016 оноос шинэ төрлийн гэмт хэрэг, тухайлбал, хар тамхи мансууруулах бодистой холбоотой, авлига, албан тушаалын гэмт хэрэг илт өссөн байна. Зөвхөн 2006 онд хар тамхитай холбоотой 6 гэмт хэрэгт 33 холбогдогч шалгагдан шийтгэгдэж байсан бол 2018 онд 197 гэмт хэрэгт 402 холбогдогч шалгагдсан буюу хэргийн тоо 32 дахин, холбогдогчийн тоо 12 дахин өссөн нь анхаарал татаж байна.Түүнчлэн Авлигатай тэмцэх газраас авлига, албан тушаалын гэмт хэргийг мөрдөн шалган, шүүхэд шилжүүлэх байдал жил ирэх тусам өсч байна.Тухайлбал, Авлигатай тэмцэх газар 2016 онд 459, 2018 онд 953 хүнд мөрдөн шалгах ажиллагаа явуулсан нь өмнөх жилүүдээс 2 дахин өссөн байна.

Зөвхөн энэ 2 гэмт хэргийн тухайд үзэхэд улсын хэмжээнд үйлдэгдэж буй нийт гэмт хэргийн бүтцэд шууд нөлөөлж, дийлэнх үйлдэгддэг гэмт хэргийн эзлэх жинг тодорхой хувиар бууруулж байна.

4. Эрх зүйн шинэтгэлийн хүрээнд батлагдсан Эрүүгийн хуульд эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг нэмэгдүүлсэн нь Монгол Улсад альтернатив ялын тогтолцоог бий болгоход чухал хувь нэмэр болсон ба Шүүхээс хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээг оногдуулах боломжийг бий болгосон байна.

5. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 2003-2018 оны хооронд нийт 105671 гэмт хэргийг хянан шийдвэрлэснээс Нийслэлд 47494 буюу 44%-ийг дангаараа эзэлж байна.Аймаг, орон нутгийн шүүх бүр эрүүгийн хэргийг хянан шийдвэрлэх явдал жил ирэх тусам өсч байгаа хэдий ч тухайлан, Дархан-Уул, Дорнод, Орхон, Өмнөговь, Өвөрхангай, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл аймгуудад илт өссөн үзүүлэлттэй байна.

6. Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс 2003-2018 оны хооронд нийт 136634 хүнд ял, эрүүгийн хариуцлагын бусад арга хэмжээ оногдуулснаас 2003 онд-72.6%, 2004 онд-70,5, 2005 онд-68,4%, 2006 онд-69,9%, 2007 онд-69,2%, 2008 онд-72,3%, 2009 онд-76,4%, 2010 онд-75,9%, 2011 онд-77,4%, 2012 онд-77,5%, 2013 онд-76,2%, 2014 онд-76,7%, 2015 онд-74,8%, 2016 онд-77,8%, 2017 онд-50,9%, 2018 онд-26,2%-д нь хорих ял оногдуулсан байна.

Дээрх хугацаанд 92892 хүнд хорих ял оногдуулсан нь нийт ял шийтгүүлэгчдийн 67,9%-ийг эзэлж байна.Түүнчлэн 42421 хүн буюу 45,5%-д нь хорих ялыг биечлэн эдлүүлжээ.

7. Шүүхээс 2004-2018 оны хооронд ял шийтгүүлсэн нийт 127605 хүнээс 9068 буюу 7,1% нь насанд хүрээгүй этгээд, 11398 буюу 8,9% нь эмэгтэйчүүд, 29576 буюу 23,1% нь урьд ял шийтгүүлсэн, 22332 буюу 17,5 нь бүлэглэж гэмт хэрэг үйлдсэн, 28389 буюу 22,2% нь согтуугаар гэмт хэрэг үйлдсэн, 83556 буюу 65,4% нь ажил, сургуульгүй хүмүүс байна.

8. Шүүхээс оногдуулсан хорих ялын хугацааг 2014-2018 оны хооронд нийт 24402 хүнд хорих ял оногдуулснаас 1-3 жил-13947 буюу 57,1%, 3-5 жил-6315 буюу 25,8%, 5-8 жил-2338 буюу 9,5%, 8-10 жил-241 буюу 0,9%, 10-15 жил-999 буюу 4%, 15-20 жил-422 буюу 1,7%, 20-25 жил-135 буюу 0,5%, бүх насаар-8 буюу 0,03%-ийг тус тус эзэлж байна.

Хоёр. Монгол Улсын 2003-2018 оны хорих ял эдлүүлэх ажиллагааны хэрэгжилт:

1. Хорих ял эдлүүлэх ажиллагаа нь хорих ялаар шийтгэгдсэн этгээдийг дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх зан үйлийг төлөвшүүлэн нийгэмшүүлэхэд чиглэгдсэн тодорхой эрхийн хязгаарлалттайгаар дэглэм, нөхцөл, журмын хүрээнд хориж буй арга хэмжээ юм бөгөөд нийгэмшүүлэх, аюулгүй байдлыг хангах гэсэн үндсэн 2 чиглэлтэйгээр зохион байгуулагддаг байна.

2. Хорих ял эдлүүлэх тогтолцоо нь хоригдлын үйлдсэн гэмт хэрэг, хувийн шинж, нийгэмшүүлэх болон аюулгүй байдлын арга хэмжээг харгалзан ялгамжтай байдлаар хорьж буй хэлбэр юм.

3. Хорих байгууллагын төрөл, дэглэмийг нээлттэй, хаалттай тогтолцоонд шилжүүлэх асуудал 2008 оноос эхлэн судалгаа шинжилгээний ажил хийгдэн 2017 онд шилжсэн ба Монгол Улсын Их хурлын 2008 оны 01 сарын 31 өдрийн 12 дугаар тогтоолоор батлагдсан "Мянганы хөгжлийн зорилтод суурилсан Үндэсний хөгжлийн цогц бодлого"-ын 6 дугаар тэргүүлэх чиглэлд заагдсан "...дэлхийн улс орнуудын эрх зүйн тогтолцооны үнэт зүйл, эрх зүйн соёл, шинэ, дэвшилтэт, түгээмэл ач холбогдол бүхий зохицуулалтын аргыг судалж нэвтрүүлэх, бусдын хууль бусаар учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх эрх зүйн орчинг бүрдүүлэх, хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах", Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "МОНГОЛ УЛСЫН ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ-2030"-д заагдсан

"Нийгмийн тогтвортой хөгжлийн зорилт нь жендэрийн тэгш байдлыг хангах, бүх нийтийг эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тусламж, үйлчилгээнд хамруулах, иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх, бүх нийтийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, иргэн бүрт хүртээмжтэй, чанартай боловсрол олгох, насан туршийн боловсролын үндэсний тогтолцоог бүрдүүлэх, зохистой хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх замаар ядуурлын бүх төрлийг эцэс болгож, нийгмийн дундаж давхаргын эзлэх хувийн жинг тууштай нэмэгдүүлэхэд чиглэх зорилтыг хангах, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 9 дүгээр сарын 09-ны өдрийн 45 дугаар тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр-ийн 5.4.10.Хорих ангийн төрөл, дэглэмийг нээлттэй, хаалттай тогтолцоонд бүрэн шилжүүлэх, цагдан хорих байрны нөхцөлийг хүний жам ёсны эрхэд нийцүүлэх, ял эдлүүлэх ажиллагаанд цахим болон теле хяналтын системийг нэвтрүүлэх, ялтныг хөдөлмөрт бүрэн хамруулах, иргэний хэргийн талаархи шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн зарим ажиллагааг онлайн хэлбэрт шилжүүлэх замаар шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг шинэтгэнэ гэсэн заалтыг хэрэгжилтыг хангасан ажил болжээ.

4. Хэдийгээр Эрүүгийн болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нээлттэй болон хаалттай хорих байгууллагын талаар тусгасан боловч тэр нь хорих байгууллагын төрөл эсхүл дэглэм эсэхийг тодорхойгүй орхисон сул талтай байна.

5. "Хорих ял эдлүүлэх дэглэм" гэдгийг нийтлэг агуулгаар нь авч үзвэл хорих ял эдлүүлэх ажиллагааны явцад үүсч бий болсон эрхийн хязгаарлалт, ял эдлүүлэх нөхцөл, журам, ялтныг нийгэмшүүлэх болон аюулгүй байдлыг хангахтай холбогдсон өөр хоорондоо ялгаа, өвөрмөц байдал бүхий үйл ажиллагааг зохицуулсан хэм хэмжээний нийлбэр юм тодорхойлбол одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан журам, зааврын хүрээнд зөвхөн эргэлт, зарим нэг хөдөлмөрийн нөхцлөөр ялгагдаж байна.

6. Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллагын тухай зохицуулалт орсон нь олон улсын жишигт нийцсэн боловч тусгайлсан журам байхгүй, сургалт, хүмүүжлийн ажил хэрхэн явах нь тодорхой бус байна.

7. Хоригдлыг нийгэмшүүлэх ажил эрх зүйн зохицуулалтын хувьд бүрэн баталгаажсан боловч, практик хэрэгжилт нь зөвхөн сургалтаар хязгаарлагдсан, сургалт нь жил ирэх тусам буурсан үзүүлэлтэй байна.

8. Хоригдлын зүгээс үйлдэж буй гэмт хэрэг, зөрчлийн тоог судлан үзэхэд 2003 онд-82 гэмт хэрэг, 2018 онд-4 гэмт хэрэг үйлдэгдсэнийг харьцуулахад 20 дахин буурсан үзүүлэлтэй байна.

9. 2018 онд хоригдлын нас баралт 15 дахин, зөрчил 2 дахин буурсан үзүүлэлтэй байгаа нь хоригдлын аюулгүй байдлыг хангах арга хэмжээ сайжирсныг илтгэн харуулж байна.

10. Хоригдлын эрхийг хангахтай холбоотой Олон улсын эрх зүйн баримт бичиг дотоодын хууль тогтоомжид бүрэн туссан, Монгол Улсын Үндсэн хууль, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд хоригдлын эрх зүйн байдлыг хангалттай хэмжээгээр тусгасан нь судалгаагаар харагдаж байна.

11. Прокурорын байгууллагаас хорих ял эдлүүлэх ажиллагаанд хяналт тавин, танилцан, зөрчил илрүүлэн, шаардлага хүргүүлсэн тоо баримт жил ирэх тусам өссөн нь онцгой анхаарал татаж байна.

12. Хорих ял эдлүүлэхтэй холбоотой хууль, тогтоомжид хоригдсон этгээдийн "Хорих байрны өрөө нь нэг хүнд 2,5 ба түүнээс дээш хавтгай дөрвөлжин метр талбай ногдохоор байна", хоригдлын "Хорих өрөө нь олон улсын стандартад нийцсэн байна", "эмнэлгийн өрөө нь 7 м/кв, сүрьеэг эмчлэх өрөө нь 7.5 м/кв талбайтай байна" гэсэн зохицуулалттай. Нэг хүнд ногдох талбайн хэмжээг 3 м/кв талбайгаар тооцон үзвэл нээлттэй хорих ангиуд 1297, хаалттай хорих ангиуд 2440, нийт 3737 хоригдол хүлээж авах багтаамжтай бол цагдан хорих байрууд нийтдээ 1915 хүний багтаамжтай бөгөөд Нийслэл дэх Цагдан хорих төв 685, орон нутаг дахь цагдан хорих байрууд 25-80 хүний багтаамжтай болно. Улсын хэмжээнд сүүлийн 10 гаруй жилийн дунджаар 6000-7000 хоригдол ял эдэлж байсан ба одоо Монгол Улсын хэмжээнд хорих ангиудын хоригдлын багтаамж нь 3737 байгаа нь хорихоос өөр төрлийн ялыг түлхүү оногдуулах зайлшгүй шаардлага байна.

АЛБА ХААГЧИЙГ АЛБАН ТУШААЛД ДЭВШҮҮЛЭХ, БУУРУУЛАХАД АНХААРАХ АСУУДАЛ БА ЧАДАХУЙН ЗАРЧИМ ХАНДЛАГАД ТУЛГУУРЛАХ НЬ



Б.ТЭМҮҮЖИН
ШШГЕГ-ын 415 дугаар хаалттай хорих ангийн төлөөлөгч, ахлах дэслэгч

Товч агуулга: Монгол Улсад төрийн албан хаагчдын нэр төдийлөн сайн биш байгаа. Төрийн үйл ажиллагаа тасралтгүй байхад албан хаагчдын чадавхи чухал үүргийг гүйцэтгэдэг. Төрийн албаны нэр хүндийг өндөрт гаргахад албан хаагчдын чадавхи маш чухал ач холбогдолтой юм. Монгол Улсад төрийн албан тушаалд чадвартай хүнийг томилох, дэвшүүлэх талаар ажлууд хийгдэж Төрийн албаны тухай хуульд мерид буюу чадахуйн зарчмыг нэвтрүүлээд байна.

Abstract: The names of public officials in Mongolia are not very good. Capacity of civil servants has an important role in continuing state activities. The public officials are very important since they reach high reputation. Special work on appointment of a capable person to work in Mongolia has been introduced into the law on government service, law on merit.

Түлхүүр үг: Төрийн алба, албан тушаал, мерид зарчим, хандлага.

Keywords: Public service, position, principle of merit, attitude.

Төрийн албаны тухай хууль шинэчлэгдэн батлагдаж 2019 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Уг хуулийн гол агуулга нь өдөр ирэх тусам хувьсан өөрчлөгдөж буй хүний хөгжлийн агуулга, мөн чанартай уялдуулан төрийн албыг орчин үеийн нийгмийн соёл, үнэт зүйлд нийцүүлэн залгуулах, улмаар бэхжүүлэхэд чиглэсэн эрх зүйн зохицуулалтыг бий болгох явдал билээ. Орчин үеийн төрийн алба нь гагцхүү чадахуйн зарчимд тулгуурлан ажиллах иргэн /төрийн алба хаагч/-ийг шинээр болон сургаж авснаар төрийн албаны "мэргэшсэн, тогтвортой, ил тод, хариуцлагатай байх эрх зүйн үндэс бүрдэх"[1] боломжтой.

[1] Төрийн албан тухай хуулийн 7 дугаар зүйл. Төрийн албаны зарчим

Алба хаагчийг албан тушаалд дэвшүүлэх, бууруулах асуудал нь өнөөгийн нийгэмд дан ганц тухайн төрийн алба хаагчийн мэдлэг, ур чадвартай холбоотой асуудал бус "хандлага" гэгч үнэт зүйлтэй салшгүй холбоотой. Хандлага бол соёлт нийгмийн нэгж буюу хүний салшгүй нэг хэсэг бөгөөд ялангуяа чадахуйн зарчим "хуульчлагдсан" өнөөгийн нийгэмд "хандлага"-ын талаар ярихгүй орхигдуулж огт боломгүй.

Чадахуйн зарчимд нийцэхгүй төрийн алба хаагчийг албан тушаал бууруулах буюу "чадахгүй"-н зарчмыг баримталж, хариуцлагын асуудлыг хөндөх нь зүй ёсны боловч түүний хандлагыг мөн л харгалзаж үзэх хэрэгтэй. Иймд ШШГБ-ын алба хаагчийг албан тушаалд дэвшүүлэх, бууруулахад тухайн алба хаагчийн хандлагыг нэн түрүүнд харгалзаж, тэрхүү хандлага нь чадахуй болон чадахгүйн зарчимтай хэрхэн уусч байгааг дүгнэж үзэх нь чухал байна.

Судалгааны ач холбогдол

Төрийн алба хаагчийг албан тушаалд дэвшүүлэх, бууруулахад тодорхой цаг хугацааны хязгаар зааж, түүний хандлагыг харгалзан чадахуй, чадахгүйн зарчимд тулгуурлан ажиллахын ач холбогдол яагаад чухал вэ? Энэ асуултад хариулт олохын тулд эдгээр зарчимд нийцэх цаг хугацааны шалгуурыг журамлан тогтоосон эрх зүйн баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийх, бодит байдалд хэрхэн нийцэж байгааг нь судлан оношлох нь чухал. Мөн эдгээр эрх зүйн баримт бичгүүд нь бодит амьдралд хэрхэн нийцэж, хөрсөн дээрээ хэрхэн бууж байгааг ярилцлагын аргаар судалж, оношлон дүн шинжилгээ хийж, цаашид анхаарах асуудлыг тоймлон тогтоож гэмээ нь энэхүү судалгааны ажлын ач холбогдол орших билээ.

Нөгөө талаас төрийн албанд ёс зүй, сахилга хариуцлага чухлаар яригдах болсон өнөө үед төрийн жинхэнэ албаны чадахуйн зарчим нь хандлагад тулгуурлахын ач холбогдол, чухам яагаад хандлагад тулгуурлах шаардлагатай талаар хөндөхийг энэхүү судалгаагаар дамжуулан илэрхийлэхийг зорьлоо.

Үндсэн хэсэг

Судалгааны ажлын үндсэн агуулгын хүрээнд:

- ШШГБ-ын алба хаагчийг албан тушаалд дэвшүүлэх, бууруулах үйл ажиллагаатай холбогдох эрх зүйн орчин, анхаарах асуудлуудын талаар хөндөх
- Чадахуйн зарчим хандлагад тулгуурлах тухай, түүний онол, эрх зүйн орчин

➢ Алба хаагчийг албан тушаалд дэвшүүлэх, бууруулахад чадахуйн зарчимыг хэрхэн баримтлах, хандлагад тулгуурлахын ач холбогдлыг судалгааны үр дүнд тулгуурлан тусгах зэрэг асуудлуудыг хөндлөө.

Албан тушаалд дэвшүүлэх:

"ШШГБ-ын алба хаагчийг албан тушаалд дэвшүүлэх, бууруулах, өөр албан тушаалд шилжүүлэн томилох журам"-д: "Төрийн жинхэнэ алба хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэх журам"-д зааснаар сүүлийн 3 жил дараалан "А" буюу "маш сайн" үнэлэгдсэн, тухайн ажлын байранд тавигдах ерөнхий болон тусгай шаардлага хангаж байгаа сахилгын шийтгэлгүй алба хаагчийг .... албан тушаалд дэвшүүлж болно гэж заасан.

Уг журамд "ахлагчийн бүрэлдэхүүнд 3-аас доошгүй жил ажилласан..., албан тушаалд томилогдоод 5-аас доошгүй жил, үүнээс офицерын албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан..., албан тушаалд томилогдоод 8-аас доошгүй жил, үүнээс ахлах албан тушаалд 3-аас доошгүй жил ажилласан..." гэхчилэн алба хаагчийг албан тушаал дэвшүүлэн томилох асуудалд цаг хугацааны шалгуур болон ажлын дадлага, туршлагын талаар тусгасан. Энэ нь цаанаа тухайн албан тушаалд томилогдох алба хаагчийн сэтгэл зүйн бэлтгэл, хандлагын тухай илэрхийллийг агуулж байгаа хэрэг.

ШШГБ-ын алба хаагчийг албан тушаалд дэвшүүлэхэд баримтлах хамгийн нарийвчилсан хууль эрх зүйн баримт бичиг бол ердөө л энэ. Гэтэл дээрх журам 2018 онд батлагдсан буюу шинэчлэн батлагдсан Төрийн албаны хууль болон Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль хүчин төгөлдөр болсоноос хойш батлагдсан хэдий ч 2012 онд батлагдсан "Үр дүнгийн гэрээ дүгнэх" журмын хүрээнд асуудлыг шийдвэрлэхээр тусгагдсан байгаа нь журмыг шинэчлэн найруулах шаардлагатай болохыг харуулж байна.

Албан тушаал бууруулах:

Алба хаагч тухайн албан тушаалд ажиллах шаардлага хангахгүй байгаа тухай дүгнэлт нь түүнийг захиргааны санаачлагаар албан тушаал бууруулах үндэслэл болно. Энэхүү дүгнэлтийг ШШГТ болон Төрийн албан тухай хуульд заасны дагуу алба хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээг үндэслэн эрх бүхий албан тушаалтан, салбар нэгжийн дарга гаргана.[2]

[2] ШШГБ-ын алба хаагчийг албан тушаалд дэвшүүлэх, бууруулах, өөр албан тушаалд шилжүүлэн томилох журам. 4 дэх хэсэг

"ШШГБ-ын албаа хаагчийг албан тушаалд дэвшүүлэх, бууруулах, өөр албан тушаалд шилжүүлэн томилох журам"-д албан тушаал бууруулах тухай ийнхүү заасан. Гэтэл Төрийн албаны тухай хууль, ШШГТ хууль, Хорих ангийн харуул хамгаалалтын журам, ШШГБ-ын ажилтны сахилга, ёс зүйн дүрэм зэрэг эрх зүйн баримт бичгүүдэд албаа хаагчдад ногдуулах сахилгын шийтгэл буюу албан тушаал бууруулахтай холбоотой заалтуудыг тодорхой тусгаж өгсөн.

Албан тушаал бууруулан томилогдсон албаа хаагч нь шинээр томилогдсон албан тушаалдаа хэрхэн эзэн болж, ямар хандлагатай ажиллаж байгааг нь харгалзан буцааж албан тушаалд томилох, цаашид дэвшүүлэн томилох асуудлыг хэлэлцдэг. Энэ бол жинхэнэ чадахуйн зарчимыг баримталж байгаа явдал юм.

Чадахуйн зарчим ба хандлага:

Төрийн албаны тухай хуульд: "чадахуйн зарчим /мерит/" гэж иргэнийг төрийн албанд сонгон шалгаруулж томилох, чөлөөлөх, ажлын гүйцэтгэлийг нь үнэлэх, дэвшүүлэх, шагнаж урамшуулах асуудлыг шийдвэрлэхдээ хувь хүний мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвар, туршлага, ажлын үр дүнд тулгуурлахыг ойлгох талаар тусгасан. Гэтэл чадахуйн зарчимын тодорхойлолтод яагаад "хандлага" гэсэн үг харагдахгүй байна вэ?

Нийгмийн шинжлэх ухаан талаас нь авч үзвэл:

Г.Мөнхнаран тодорхойлохдоо: Мерит бол Спойл зарчим юм.

"Мерит гэдэг үг нь гавъяа зүтгэл, чанар чансаа, сайн тал, хүлээн зөвшөөрөгдсөн байдал" гэсэн утгатай. "Мерит зарчим" гэдэг нь төрийн мэргэшсэн албаны томилгоог улс төрийн хуваарилалт, захиалгаар бус түүнээс бүрэн ангид бөгөөд шударгаар өрсөлдүүлэн шалгаруулах зарчмаар төрийн албанд томилох болон зөвхөн хүлээн зөвшөөрөхүйц зүтгэл, үр дүн гаргасныхаа үнэлэмжээр албан тушаал дэвших тухай тогтсон үзэл баримтлал юм.[3] Үүнээс үзэхэд Мерит буюу чадахуйн зарчим бол зөвхөн ур чадвар, ажлын үр дүнд тулгуурлах тухай ойлголт болох нь харагдаж байна. Гэтэл Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлд: "Төрийн албаны зарчим" хэсэгт "төрийн жинхэнэ албан тушаалд иргэнийг томилохдоо гагцхүү чадахуйн зарчмыг баримтлах" тухай заасан. Тэгвэл төрийн жинхэнэ албан тушаалтан болохын тулд аливаад хандах эерэг хандлагагүй

[3] Г.Мөнхнаран. Төрийн удирдлагын тогтолцоо. 156 дахь тал

байх ёстой юм гэж үү? Нэг талаас энэ асуулт өрөөсгөл мэт санагдаж байгаа байх. Гэхдээ л энэ бол томъёоллын хувьд үнэнд нийцэх ойлголт.

Тэгвэл "Спойл" зарчим буюу "Спойл" тогтолцоо гэж юу вэ? Энэ нь "Ашиг хуваарилах" буюу эвдрэх тогтолцоо. Төрийн удирдлагын мэргэжлийн боловсон хүчин тогтворгүй, улс төрийн сонгуулиар удирдлагын бүх бүтэц өөрчлөгдөж, төр захиргааны багийг ажлын аппараттай нь хамт цоо шинээр бүрдүүлдэг явдал юм.[4] Энэхүү тайлбараас үзэхэд Мерит буюу спойл зарчимд ямар ч хандлага, ёс зүй, сэтгэлгээний тухай ойлголт огт харагдахгүй байна.

Уг хуулийн 52 дугаар зүйлд: "Төрийн жинхэнэ албан хаагчийг албан тушаал дэвшүүлэх, цалин хөлсийг өөрчлөх, цол, зэрэг дэв олгох, урамшуулах, зохих шатны сургалтад хамруулах, албан тушаал бууруулах, хариуцлага хүлээлгэх асуудлыг түүний ажлын гүйцэтгэл, үр дүнг үндэслэн шийдвэрлэнэ" гэжээ. Энэ нь цэвэр зарчимын шинжтэй агуулга. Төрийн алба хаагчтай холбоотой дээрх шийдвэрүүдийг гаргахдаа зөвхөн түүний ажлын гүйцэтгэл, үр дүнг үндэслэн шийдвэрлэнэ гэх ойлголт нь чадахуйн зарчимд тулгуурлан шийдвэр гаргах тухай хуулийн үндсэн агуулгыг л илэрхийлсэн. Гэтэл нөгөө л чадахуйн зарчим нь хандлагыг багтаагаагүй агуулга тэр чигээрээ буюу хандлагыг орхигдуулсан ойлголт хэвээр л туссан байна.

Хандлагын талаар тусгасан ганц зүйл бол:

"Төрийн жинхэнэ алба хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж, дүгнэх журам"-ын 1.3.4 дэх хэсэгт заасан дараах заалт.

"Мэдлэг чадвар" гэж байгууллагын зорилго, зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд тухайн төрийн жинхэнэ албан хаагчаас зайлшгүй шаардагдах мэдлэг, ур чадвар, **хандлага,** зан үйлийг ойлгох тухай заалт юм.

Эдгээр ойлголтуудыг жишээн дээр тайлбарлъя. ШШГБ-ын сүүлийн 3 жилд дэвшүүлсэн зорилт: 2017 онд "Дэвшил, чанар, ёс зүйг дээшлүүлэх", 2018 онд "Алба хаагчдын мэдлэг, ур чадвар, ажлын гүйцэтгэл, манлайллыг дээшлүүлэх", 2019 онд "Сахилга, хариуцлага, ёс зүй, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх". Эдгээрээс харахад алба хаагчдын ёс зүй, хандлагыг чухалчилсан зорилтууд дэвшүүлж байгаа нь анзаарагдаж байна. Гэтэл алба хаагчдыг албан тушаалд дэвшүүлэх, бууруулах тохиолдол гэлтгүй албан тушаалд сонгон шалгаруулж авах тохиолдол бүртээ зөвхөн чадахуйн

[4] Г.Мөнхнаран. Төрийн удирдлагын тогтолцоо. 164 дэх тал

зарчимд тулгуурлаж, ёс зүй, харилцаа, хандлагын агуулгыг орхигдуулсан байна.

Тэгвэл хандлага гэж юу вэ? Энэ нь нөхцөл байдал болон бусад хүмүүсийг тааламжтай ба тааламжгүй аль нэг байдлаар үнэлэх үнэлэлт юм. Харилцаа хандлага хоѐр нягт холбоотой бөгөөд харилцааны явцад хандлага мэдрэгддэг. Хандлага үйлдэл болохдоо бодлоор дамжин илэрдэг. Ёс зүй нь хүний дотоод сэтгэлийн төгөлдөршилтэй нягт холбогддог бөгөөд энэ нь харилцаа хандлагын хэлбэрээр илэрдэг. Хандлага оюун ухаанаас илүү чухал. Яагаад гэвэл: Сэтгэл судлаач Карол Двек бүхий л хугацааг хандлага болоод гүйцэтгэлийн талаар судлахад зарцуулсан ба тэрээр судалгаагаараа таны амжилтыг IQ биш хандлага тодорхойлдог гэдгийг баталсан байна.[5]

Гэтэл "Хандлага" бол мэдлэг, ур чадвартай зэрэгцэн орших нийгмийн шинжлэх ухааны ухагдахуун, чадахуйн зарчимын тулгуур, үндсэн ойлголт. Аливаад хандах эерэг хандлагагүйгээр мэдлэгтэй, ур чадвартай байлаа ч чадахуйн зарчимд нийцэж ажиллана гэж үгүй. Учир юу вэ гэдгийг алба хаагчдаас авсан судалгааны үр дүнгээс харцгаая.

Бүлгийн ярилцлагын аргаар авсан судалгааны үр дүн:

1. Алба хаагчийг албан тушаалд дэвшүүлэх асуудалд дараах хэд хэдэн зүйлийг анхаарах:

- Албан тушаалд дэвшинэ гэдэг бол тодорхой түвшинд бусдыг удирдана, манлайлна гэсэн үг. Тиймээс удирдах арга барил, манлайллын тодорхой суурь ойлголт тухайн албан тушаалтанд заавал байх ёстой. Түүнийгээ баяжуулах буюу чухам аль арга барилаар ажиллах нь тухайн хүний сонголтын асуудал.
- Албан тушаалд дэвшүүлэхдээ зөвхөн мэдлэг, ур чадвар, ажлын дадлага туршлага буюу ажилласан жил зэргийг харгалзан үзэх бус хүнтэй харилцах харилцааны ур чадвар, ёс зүй, сэтгэлгээ болон хандлагыг заавал харгалзаж үзэх. ШШГБ-ын онцлог бол аль ч түвшинд, аль ч албан тушаалд хүнтэй ажилладаг онцлогтой байдаг. Тиймээс хүнтэй харилцах харилцаа, хандлагын асуудал хамгаас чухал.
- Чадахуйн зарчим бол ур чадвар, чадал чансаанд тулгуурлан ажиллах зарчим. Гэхдээ ШШГБ-ын онцлог буюу хүнтэй ажилладаг тогтолцооны хувьд сэтгэл буюу хандлагын асуудлыг заавал харгалзаж үзэх ёстой. Манай системийн ихэнхи удирдах албан тушаалтнуудын сул тал

[5] Л.Оюун-Эрдэнэ. Мэдлэг, ур чадвар, хандлага. 89 дэх тал

гэвэл аливаа зүйлийг хүчээр шийдэх явдал юм. Магадгүй "цэргийн" гэдэг утгаараа байж болох ч орчин үеийн нийгмийн ухамсар, өөрчлөлтийг даган өөрчлөгдөж буй төрийн албаны зарчим, үнэт зүйлд энэ арга барил нийцэхгүй. Ингэж аливаа зүйлийг хүчээр шийдсэнээс болж маш олон сөрөг үр дагаварууд гардаг. Тухайлбал: Алба хаагчидтай элдэв бүдүүлэг үг хэллэг хэрэглэн харьцах, үүрэг өгөхдөө хүчээр биелүүлэхийг шаардах, алба хаагчдыг зөвхөн цалингаар нь барьж тогтоох арга барилаар ажиллах зэрэг. Эдгээр нөхцөл байдал бол удирдлагын харилцаа, хандлагын асуудал юм. Энэ байдлаас шалтгаалан алба хаагчид ажлаас халшрах, шантрах, боловсон хүчиний тогтвор суурьшилгүй байдал бий болох гэх мэт.

- Албан тушаалд дэвшүүлэн томилохдоо мэдлэг, ур чадвар, хандлага, туршлагыг үндэслэн холбогдох хууль, журамд заасан хугацаа буюу цаг хугацааны шалгуурыг үндэслэн томилох нь чухал. Эдгээрээс хамгийн чухал нь хандлагын асуудал гэдгийг сайтар анхаарах хэрэгтэй.
- Тэгвэл яагаад өөрийн хүсэлтээрээ албан тушаал дэвших боломжийг алба хаагчдад бий болгож болохгүй гэж? Шууд утгаараа энэ нь тухайн алба хаагчийг цээжээ дэлдсэн, чадалдаа эрдсэн болгож харуулах боловч энэ нь тухайн алба хаагчийн өөртөө итгэх итгэлийг харуулж байгаа хэрэг. Гэхдээ манай тогтолцоонд ийм зүрхтэй алба хаагч төдийлөн гарахгүй биз.

2. Алба хаагчийг албан тушаалд буурууллан томилоход анхаарах асуудал:

- Албан тушаал буурна гэдэг нь 2 өөр ойлголтыг агуулна.

1-рт: Өөрийн хүсэлтээрээ албан тушаал буурч байгаа тохиолдол бол төдийлөн анхаарал хандуулах асуудал бус.

2-рт: Захиргааны санаачлагаар буюу "чадахгүйн" зарчмаар албан тушаал буурч байгаа тохиолдолд тухайн алба хаагчийн сэтгэлгээ, хандлагыг маш нарийн анзаарч харах нь чухал. Өөрөөр хэлбэл албан тушаал буурлаа хэмээн сэтгэлийн хатгүй, өмнө ажиллаж байснаасаа дор, буурай ажиллаж, албан ажилдаа сэтгэлгүй хандаж байвал энэ нь тухайн алба хаагчийн сөрөг хандлагыг харуулж байгаа хэрэг. Ийм алба хаагчид ихэвчлэн дахин албан тушаалдаа очихын тулд танил тал, найз нөхдийн хүрээллийг хүсч, авлига, хахуулийн аргаар ч болтугай хуучин албан тушаалдаа очихыг хүсдэг. Энэ тохиолдолд чадахуйн зарчимын тухай ярих ч хэрэггүй биз.

➢ Албан тушаал бууруулан томилох асуудал бол хуулинд заасан сахилгын шийтгэлийн нэг хэлбэр. Алба хаагч хуулинд заасан тодорхой цаг хугацааны шалгуур буюу сахилгын шийтгэлийн үйлчлэх хугацааг өөрт ашигтайгаар буюу өөрийн алдаандаа дүгнэлт хийж, мэдлэг, ур чадвар, хандлага, туршлагаа эерэгжүүлэн ашиглаж чадвал хуучин албан тушаалдаа томилогдоод зогсохгүй цаашид ч дэвшин томилогдох боломж нээлттэй байдаг.

➢ Дээр дурьдсан цаг хугацааны шалгуур буюу сахилгын шийтгэлийн үйлчлэх хугацаанд тухайн алба хаагч ямар хандлагаар, хэрхэн ажиллаж байгааг тухайн байгууллага, салбар нэгжийн удирдлага, боловсон хүчин хариуцсан алба хаагчид нарийн анзаарч, үнэлэлт дүгнэлт өгөх нь чухал.

➢ Албан тушаал буурч томилогдсон алба хаагч өөрийн хандлага, сэтгэлгээгээ эерэгжүүлж, цаг хугацааны шалгуурыг зохистой даван туулж чадсан тохиолдлыг манай удирдлагууд анзаарч цаашид албан тушаалд дэвшүүлэн томилох асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх нь чанартай удирдлага, боловсон хүчинийг бэлтгэхэд чухал ач холбогдолтой байж болох юм.

3. Чадахуйн зарчим хандлагад тулгуурлах нь:

➢ Чадахуйн зарчим /Мерит зарчим/-ыг баримтлан алба хаагчийг албан тушаалд дэвшүүлэх асуудал бол маш зөв зүйтэй санаа. Энэ нь зарим талаараа шатлан дэвших гэсэн утга агуулгыг илэрхийлдэг. Гэхдээ шат алгасахгүй дэвших асуудал хамгаас чухал. Шат алгассан тохиолдолд мерит зарчим алдагдаж элдэв хардлага, сэрдлэг төрүүлэх нь мэдээж.

➢ Чадахуйн зарчимын тодорхойлолтод хандлагыг тусгаж өгөөгүй нь буруу зүйл. Учир нь хүнтэй ажилладаг төрийн алба, нийгмийн шинжлэх ухаанд хандлага бол маш чухал зүйл. Нийгэм бол хүмүүс хоорондын харилцаа гэж ойлгогддог шиг төрийн алба, ялангуяа жинхэнэ алба бол хандлага, сэтгэлгээний тухай ойлголт юм. Чадаж байгаа боловч эерэг хандлагагүй, сэтгэлгүй бол төрийн алба юу болж хувирах вэ? Хандлага бол ёс зүй, хариуцлагыг хүртэл багтаасан өргөн утгатай ухагдахуун.

➢ Хандлагыг 2 төрөлд авч үзэх:

1-рт: Хүнтэй харилцах харилцаа, хандлага

2-рт: Ажилдаа хандах сэтгэлийн хандлага. Аль ч төрөл нь бай сэтгэлгээний асуудал хөндөгдөнө.

➢ Нөгөө талаас зөвхөн харилцаа, хандлага, сэтгэлийн үнэлэмжээр чадахуйн зарчимыг тодорхойлж болохгүй. Мэдлэг, ур чадвар, хандлага,

туршлага, ажлын үр дүн тэр бүгд цогцоороо чадахуйн зарчимыг бүрдүүлнэ. Эдгээрийн үндэс суурь нь хандлага юм. Албан тушаалд дэвшүүлэх, бууруулах аль ч тохиолдолд дараах гурвалжинг заавал анхаарах шаардлагатай. Эдгээрээс хамгийн чухал нь "Хандлага" юм.



ДҮГНЭЛТ

ШШГБ-ын алба хаагчийг албан тушаалд дэвшүүлэх, бууруулахад анхаарах асуудлуудын хамгийн гол цөм нь манай байгууллагын онцлог нөхцөл байдал буюу аль ч түвшинд хүнтэй ажилладаг гэдгийг онцгой анхаарах нь чухал. Хүнтэй ажиллана гэдэг бол тухайн алба хаагч, албан тушаалтны харилцааны ур чадвар, ёс зүй, хариуцлага хүлээх чадварын түвшинд яригдана гэсэн үг. Энэ бүхнийг багтаасан багц ойлголт бол хандлага юм. Хандлага нь тухай алба хаагч, албан тушаалтны ажилдаа хандах сэтгэл, хүнтэй харилцах, ойлголцох чадвар, ёс зүй, ухамсар түүнчлэн хариуцлагын асуудлыг хөндөх цогц ойлголт. Нөгөө талаас албан тушаалд дэвшинэ гэдэг бол чадахуйн зарчимд, албан тушаал буурна гэдэг бол чадахгүйн зарчимд тус тус нийцэж шийдвэрлэгдэх тухай ойлголт. Чадахуйн зарчим нь өнөөгийн төрийн албаны соёл, үнэт зүйлд чухал байр суурь эзлэх болсон өнөө үед чадахуйн зарчим хандлагад тулгуурладаг гэдгийг анхаарах нь чухал. Энэ нь албан тушаалд дэвших, буурах аль ч тохиолдолд чадахуйн болон чадахгүйн зарчимд тулгуурлахаас илүүтэй хандлагад нь тулгуурлах, хандлагыг нь харгалзан шийдвэрлэх асуудал хамгийн чухал гэдгийг илэрхийлэхийг зорьсон энэхүү судалгааны ажлын суурь агуулга билээ. Учир юу вэ гэвэл бид ШШГБ буюу өөрөөр хэлбэл хүнтэй ажилладаг төрийн жинхэнэ албаны боловсон хүчинтэй холбоотой асуудлын тухай ярьж байгаа шүү дээ.

Эх сурвалжийн жагсаалт:

1. Төрийн албаны тухай хууль. 2 дугаар бүлэг. 7 дугаар зүйл. 2017 он.

2. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хууль /2017 он/
3. Төрийн жинхэнэ албан хаагчийн үйл ажиллагааны үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлж дүгнэх журам. 1.3.4 дэх хэсэг. 2012 он.
4. ШШГБ-ын алба хаагчийг албан тушаалд дэвшүүлэх, бууруулах, өөр албан тушаалд шилжүүлэн томилох журам. 4 дэх хэсэг. 2018 он.
5. Мөнхнаран, Г. (2011). *Төрийн удирдлагын тогтолцоо*. Улаанбаатар. Монгол
6. Оюун-Эрдэнэ, Л. (2010). *Мэдлэг, ур чадвар, хандлага*. Улаанбаатар. Монгол